



SUSTAINABILITY  
EAST ASIA LLC



ERDENE  
RESOURCE DEVELOPMENT

## ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК

Хөндий Алтны төслийн  
Техникийн бус хураангуй  
2020 оны дөрөвдүгээр сар

Sustainability East Asia ХХК  
Утас +976 7011 4921  
Факс +976 7010 4921  
Улсын бүртгэлийн дугаар:  
9019036111

801 Сан Бизнес Центр  
Ерөнхий сайд Амарын  
гудамж-29  
8 Хороо, Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар-14200  
Монгол Улс  
[mongolia@sustainability.net.au](mailto:mongolia@sustainability.net.au)

## Орчуулгын үнэн зөвд баталгаа гаргахаас татгалзах тухай

Хөндий алтны төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ESIA)-г Англи хэл дээр анхлан боловсруулж, Монгол хэл рүү хөрвүүлэв. Энэхүү баримт бичгийн албан ёсны хувилбар нь Англи хувилбар болно. Эрдэнэ Монгол ХХК уг үнэлгээг Монгол хэл рүү нягт нямбай, алдаагүй орчуулахад анхаарч ажилласан. Орчуулгын ажлын явцад үүсэж болзошгүй аливаа хүндрэл шалтгааны улмаас Англи болон Монгол хувилбарын хооронд зөрүү гарах боломжтой юм. Тиймээс танд уг баримт бичгийн орчуулгын үнэн зөвтэй холбоотой аливаа эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбарыг уншина уу. Эрдэнэ Монгол ХХК нь орчуулгын үнэн зөв, алдаагүй байдлын талаар аливаа баталгаа гаргах боломжгүй. Эрдэнэ Монгол ХХК нь орчуулгатай холбогдон шууд болон шууд бусаар үүссэн аливаа хохирлыг хариуцахгүй болохыг үүгээр мэдэгдэж байна. Та уг баримт бичгийн орчуулгын алдаа болон орчуулгыг сайжруулах талаарх санал, зөвлөмжөө [uboffice@erdene.com](mailto:uboffice@erdene.com) хаягаар ирүүлнэ үү.

## АГУУЛГА

### Тайлан

<b>1.</b>	<b>Танилцуулга .....</b>	<b>1</b>
1.1	Төслийн суурь мэдээлэл .....	1
1.2	Техникийн бус хураангуйн зорилт .....	1
1.3	БОННУ-ний зорилтуудын хураангуй .....	1
1.4	БОННУ-ний үйл явц .....	2
1.5	Техникийн бус хураангуйн хамрах хүрээ .....	4
<b>2.</b>	<b>Төслийн танилцуулга .....</b>	<b>6</b>
2.1	Төслийн товч танилцуулга .....	6
2.2	Төслийн хувилбарууд .....	8
<b>3.</b>	<b>Хууль эрх зүйн асуудал, хуулийн хэрэгжилт .....</b>	<b>9</b>
3.1	Үндэсний хууль тогтоомжийн шаардлагууд .....	9
<b>4.</b>	<b>Байгаль орчин, нийгмийн нөлөөллүүд ба бууруулах арга хэмжээнүүдийн хураангуй .....</b>	<b>10</b>
4.1	Цаг уур ба агаарын чанар .....	10
4.2	Дуу чимээ ба чичиргээ .....	11
4.3	Газрын гадарга, ландшафт, геологи, хөрс ба газар хөдлөлт .....	12
4.4	Ус .....	14
4.5	Нөлөөлөл ба менежмент .....	15
4.6	Биологийн олон янз байдлын хамгаалал .....	16
4.7	Хог хаягдал .....	18
4.8	Хүн ам зүй .....	19
4.9	Эдийн засаг болон ажил эрхлэлт .....	21
4.10	Газар ашиглалт .....	24
4.11	Соёлын өв .....	27
4.12	Хөдөлмөрийн болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал .....	28
4.13	Зам тээвэр .....	30
4.14	Хуримтлагдах нөлөөллүүд .....	31
<b>5.</b>	<b>Байгаль орчин, нийгмийн менежмент .....</b>	<b>32</b>
5.1	Төслийн БОНМ .....	32
5.2	Төслийн менежментийн төлөвлөгөө .....	32
5.3	Хяналт шинжилгээ .....	32
<b>6.</b>	<b>Оролцогч талуудын хамтын ажиллагаа, санал гомдлыг шийдвэрлэх журам .....</b>	<b>34</b>
6.1	Оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагаа .....	34

6.2	Оролцогч талуудын болон харилцаа холбооны менежментийн төлөвлөгөө .....	35
6.3	Санал гомдол шийдвэрлэх журам .....	35

## Хүснэгт

Хүснэгт 1. Нөлөөллийн эрчмийн матриц .....	3
Хүснэгт 2 Хөндий Алтны төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнүүд	32

## Зураг

Зураг 1 Монгол улсад хэрэгжүүлэх Хөндий Алтны төслийн байршил.....	5
Зураг 2 Төслийн гол бүрэлдэхүүн хэсгүүд .....	7
Зураг 3 Хөндий Алтны төслийн талбайн зохион байгуулалт .....	7
Зураг 4. Хөндий Алтны төслийн талбайн ойролцоох малчдын худгийн байршил.....	14
Зураг 5 Малчдын бүртгэлтэй өвөлжөөний газрууд .....	26

**Товчилсон үгийн жагсаалт**

АН	Алтан Нар
НБ	Нөлөөллийн бүс
БХ	Баян Хөндий
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
БОННУ	Байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОНМТ	Байгаль орчин болон нийгмийн менежментийн төлөвлөгөө
БОНБ	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Байгаль орчин, нийгмийн бодлого, 2019
ЗБХ	Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг
БОНЕУ	Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ
ЭМААБОН	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нийгэм
НХХБ	Нэгдсэн хог хаягдлын байгууламж
ХАТ	Хөндий Алтны төсөл
ГМЯ	Гол мэдээлэгчийн ярилцлага
ХЦ-БС	Хүрэн цав болон Босгын сайр цооногийн талбайд
АМТЗТ	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбай
ТББ	Төрийн бус байгууллага
ТБХ	Техникийн бус хураангуй
ГШ	Гүйцэтгэлийн шаардлага
СИЭ	Састайнабилити Ийст Эйжиа ХХК
ОТХХМТ	Оролцогч талуудын болон харилцаа холбооны менежментийн төлөвлөгөө
УХТ	Усны хяналтын төлөвлөгөө
УНМТ	Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө

## 1. ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн суурь мэдээлэл

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк нь (ЕСБХБ) Эрдэнэ Монгол ХХК болон Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорацид Хөндий Алтны төслийг (ХАТ) хөгжүүлэх санхүүжилт олгохоор судалж байна.

Хөндий Алтны төсөл нь Монгол улсын Баянхонгор аймгийн нутагт, Улаанбаатар хотоос баруун-урд зүгт ойролцоогоор 980 км зайд, Баянхонгор хотоос урд зүгт 300 км-ийн зайд оршино. Хөндий Алтны төсөл нь Хөндий болон Цэнхэр номин ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудад тус тус байрлах Баян хөндий болон Алтан нар гэсэн хоёр ордуудаас бүрдэнэ. ХАТ-ийн талбай нь Шинэжинст (Баянхөндий орд) болон Баян-Өндөр (Алтан Нар орд) сумдын нутагт оршино. Хамгийн ойрын суурин газрууд (сумын төв) нь Шинэжинст болон Баян-Өндөр сумд ба ойролцоогоор зүүн-хойд зүгт 70 км, хойд зүгт 80 км-т тус тус оршино (Зураг 1).

Баян Хөндий төслийн талбайг холбогдох боловсруулах үйлдвэр, уул уурхайн дэд бүтцийн хамтаар эхэлж хөгжүүлэх болно. Үйл ажиллагааны 7 дах жилээс Алтан Нар ордыг цөөн тооны байгууламж бүхий дагуул үйл ажиллагаатай хөгжүүлэхээр санал болгосон. Олон нийтэд нээлттэй төслийн талбайн зам нь Баян хөндий тусгай зөвшөөрлийн талбайг Шинэжинст сум болон ХАТ-ийн хүрээнд Баян хөндийгөөс урд зүгт 2-5 км-т төлөвлөгдөж буй ус нийлүүлэлтийн цооногтой холбоно.

ЕСБХБ-ны зүгээс ХАТ-ийг “А” ангиллын төсөл гэж ангилсан бөгөөд энэ нь банкны Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ 2014) болон Гүйцэтгэлийн шаардлагуудад (ГШ) нийцэхийн тулд ХАТ-ийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн иж бүрэн үнэлгээ хийх шаардлагатай гэсэн үг. Састайнабилити Ийст Эйжиа (СИЭ) болон Рэмболл Австралиа болон Эко Трэйд ХХК нарыг тус БОННУ-г хийхээр гэрээлсэн болно. Тус техникийн бус хураангуй нь ЕСБХБ-ны БОНБ болон ГШ зэргийг хангахад зориулсан хэд хэдэн бичиг баримтын нэг ба, дараах баримт бичгүүд мөн орно:

- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ);
- Байгаль орчин болон нийгмийн менежментийн төлөвлөгөөнүүд (БОНМТ-үүд);
- Оролцогч талуудын болон харилцааны холбооны менежментийн төлөвлөгөө (ОТХХМТ).

### 1.2 Техникийн бус хураангуйн зорилт

Тус ТБХ-н зорилт нь БОННУ-ний мэдээллийн хураангуйг ойлгомжтой байдлаар хүргэхэд оршино. Хураангуй нь төслийн тухай болон Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үр дүн, байгаль орчин, нийгмийн эерэг болон сөрөг нөлөөллийн талаар авах менежментийн арга хэмжээнүүд, мөн оролцогч талуудын хамтын ажиллагаа, санал гомдол зэргийн талаарх мэдээллийг олон нийтэд олгоно.

### 1.3 БОННУ-ний зорилтуудын хураангуй

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь дараах зорилтуудтай болно:

- Төслийн боломжит сөрөг болон эерэг нөлөөллийг аль алиныг нь тодорхойлох ба үнэлэх;

- Ажилчид, нөлөөлөлд өртсөн орон нутаг, хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хэрэв боломжгүй бол бууруулах, багасгах, нөхөн олговор олгох;
- Нөлөөлөлд өртсөн хүн амтай тухайн хүн амын амьдралын нөхцөл байдалд нөлөөлж болзошгүй асуудлуудаар зохих харилцаа холбоог ханган ажиллах; мөн,
- Менежментийн системүүдийг хэрэгжүүлснээр нийгэм, байгаль орчны чиглэлд Компаний үр дүнтэй ажиллагааг дэмжих.

#### 1.4 БОННУ-ний үйл явц

Анхан шатны үнэлгээний үед ЕСБХБ-ны зүгээс ХАТ-ийг “А” гэж ангилснаар Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдэх шаардлагатай болсон ба дараах үйл явц нь цаашдын үнэлгээний хэсэг болон хийгдсэн болно:

- БОННУ-ний урьдчилсан үнэлгээ
- Нөлөөллийн үнэлгээ
- Нөлөөллийг бууруулах арга хэмжээг боловсруулах
- Хуримтлагдах нөлөөллийг авч үзэх

Дээрх үйл явцын даалгавруудыг дараагийн хэсгүүдэд товч тайлбарласан байгаа болно. Дэлгэрэнгүй мэдээллийг АЗ: Арга зүйн бүлэг-т бий.

##### 1.4.1 БОННУ-ний урьдчилсан үнэлгээ

Урьдчилсан үнэлгээ нь нөлөөллийн үнэлгээний үйл явцын гол хэсэг ба ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 1 (ГШ)-ийн нөхцөл болно. Урьдчилсан үнэлгээгээр БОННУ-ний доорх шаардлагуудыг олж тогтоосон болно:

- Үнэлгээний түр зуурын, орон зайн болон техникийн цар хүрээ
- Байгаль орчин, нийгмийн суурь нөхцөлийг тодорхойлох;
- Мэргэжлийн судалгааны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;
- Байгаль орчин, нийгмийн болзошгүй асуудал, нөлөөллийг онцлох; мөн
- Нөлөөллийг үнэлэх, урьдчилан сэргийлэх мөн бууруулах аргачлалыг тоймлох.

Урьдчилсан үнэлгээний тайланг 2019 оны 10 сард ХАТ-ийн техникийн багийн тусламжтайгаар БОННУ-ний баг боловсруулсан болно.

##### 1.4.2 Нөлөөллийн үнэлгээ

Энэхүү байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээнд нөлөөллийн үнэлгээ ба нөлөөллийн эрчмийг тодорхойлохдоо аль болох тодорхой стандарт, хүлээн зөвшөөрөгдсөн/хэвлэгдсэн шалгуур үзүүлэлтүүд ба хууль тогтоомжуудыг ашигласан. Нөлөөлөл, үр дагаврыг хэмжих боломжгүй тохиолдолд шинжээчийн мэдлэг ба мэргэжлийн үнэлгээг ашиглан чанарын үнэлгээ хийсэн болно. Эргэлзээ үүссэн үед тэдгээрийг тухайн холбогдох бүлгүүдэд тодорхойлж бичсэн.

Нөлөөлөл ба үр дагаврын эрчмийг тухайн нөлөөллийн цар хэмжээ ба нөлөөллийг хүлээн авагчийн эмзэг мэдрэмтгий чанар хоорондын харилцан үйлчлэлийг тогтоох замаар

тодорхойлсон. Нөлөөллийн цар хэмжээ гэдэг бол тухайн нөлөөлөлд өртөгч суурь төлөв байдлаас өөрчлөгдсөн өөрчлөлтийн хэмжээс юм. Тухайн нөлөөллийн хэмжээ, үргэлжлэх хугацаа, давтамж ба сөрөг нөлөөллөөс эргэн сэргэх чадавх зэрэг олон хүчин зүйлийн авч үзэж нөлөөллийн цар хэмжээг тодорхойлдог. Нөлөөллийг хүлээн авагчийн мэдрэг байдлыг үнэлэхдээ тухайн нөлөөлөлд тэсвэрлэх чадвар ба мэдрэг чанарт нөлөөлөх утгуудыг холбогдох оролцогч талууд ба дүрэм журмаар тодорхойлсноор авч үзсэн.

Нөлөөллийн хэмжээ ба хүлээн авагчийн мэдрэг байдлын харилцан үйлчлэлээр тухайн нөлөөллийг эрчмийг тодорхойлсон. Үүнийг нөлөөллийн эрчмийн матрицыг ашиглан хийв (Хүснэгт 1). Жишээлбэл энэхүү матрицыг ашиглан бага хэмжээтэй нөлөөлөл дунд зэрэг мэдрэг хүлээн авагчтай харилцан үйлчилж Бага эрчимтэй нөлөөлөл үүсгэхийг тодорхойлно. Дунд буюу түүнээс дээш эрчимтэй нөлөөллүүдийг бууруулахад тэргүүн ач холбогдол өгч бууруулах арга хэмжээ авна.

### Хүснэгт 1. Нөлөөллийн эрчмийн матриц

Нөлөөллийн эрчмийн матриц			
Нөлөөллийн хэмжээ	Хүлээн авагчийн мэдрэг байдал		
	Бага	Дунд	Өндөр
Ашигтай	Эерэг	Эерэг	Эерэг
Маш бага	Ялимгүй бага	Ялимгүй бага	Бага
Бага	Ялимгүй бага	Бага	Дунд
Дунд	Бага	Дунд	Их
Өндөр	Дунд	Их	Их

#### 1.4.3 Нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг боловсруулах нь

Тухайн холбогдох нөлөөлөл тус бүрд зохих арга хэмжээг боловсруулсан ба үүнд тухайлсан ямар хариу үйл ажиллагаа хийхийг тайлбарласан. Нөлөөллийг бууруулах ба менежмент хийх арга хэмжээнүүдээс гадна Хөндий Алтны төслийн үргэлжлэх хугацааны туршид үлдэгдэл нөлөөлөлд менежмент хийх арга замыг ХАТ-ийн Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнд (БОНМТ) багтаасан ба энэ нь энэхүү БОННУ-ий бүрэлдэхүүн хэсэг юм. Нөлөөллийг бууруулах арга хэмжээг дараах шат дараалалтайгаар авч хэрэгжүүлнэ:

- Төслийн зураг төслийн анхлан боловсруулах явцдаа болзошгүй нөлөөллүүдийг “зураг төслийн шатанд зайлсхийх” аргыг ашиглах;
- Төслийн өөр боломжит хувилбаруудад үнэлгээ хийж хэрэв боломжтой бол илүү бага нөлөөлөлтэй хувилбарыг сонгон хэрэгжүүлэх;
- Үлдэгдэл нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх; буюу
- Дээрх арга хэмжээнүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлсний дараа үлдэх үлдэгдэл нөлөөллүүдэд ашиглах шударга нөхөн төлбөрийг арга хэмжээг бий болгох.

Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний цогц нь 15 бие даасан тусдаа менежментийн төлөвлөгөөнөөс тогтох ба эдгээр нь биофизик ба нийгмийн эмзэг нөлөөлөл хүлээн авагчдад зориулан боловсруулсан нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг танилцуулсан байх ба эдгээрийг хэрэгжүүлэхийн тулд ХАТ-ийн хүлээн үүрэг хариуцлага, хяналт шинжилгээ болон тасралтгүй сайжирч байх явдлыг хангах аудитын шаардлагуудыг мөн багтаасан байна.



#### 1.4.4 Хуримтлагдах нөлөөллийг авч үзсэн байдал


ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 1, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ ба менежмент хэсэгт Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд төслөөс үүсэж болзошгүй хуримтлагдах нөлөөлөл болон төслөөс гадна өөр бүтээн байгуулалтуудаас үүсэх нөлөөллүүдийг авч үзэхийг шаардсан байдаг. Хөндий Алтны төслийн хуримтлагдах нөлөөллүүдийг тус бүс нутагт хэрэгжиж байгаа нь мэдэгдэж буй бусад бүтээн байгуулалтуудтай уялдуулан үнэлэв.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд авч үзсэн хуримтлагдах нөлөөллүүдийг цар хүрээг Бүлэг С14: Хуримтлагдах нөлөөллүүд хэсэгт дэлгэрүүлж үзүүлэв.

#### 1.5 Техникийн бус хураангуйн хамрах хүрээ

Техникийн бус хураангуйд дараах сэдвүүдийг авч үзсэн:

- Төслийн танилцуулга ба бусад авч үзсэн хувилбарын танилцуулга
- Төслийн барилга угсралт ба ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой үүсэх байгаль орчин, нийгмийн гол нөлөөллүүд ба тэдгээр сөрөг нөлөөллийг бууруулах болон ашигтай нөлөөллийг нэмэгдүүлэх менежментийн арга хэмжээнүүдийн тойм; мөн
- Оролцогч талууд ба харилцаа холбооны менежментийн төлөвлөгөө ба Гомдол санал барагдуулах журам



Зураг 1 Монгол улсад хэрэгжүүлэх Хөндий Алтны төслийн байршил

## 2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 2.1 Төслийн товч танилцуулга

ХАТ нь “грийнфилд” буюу урьд нь төсөл хэрэгжиж байгаагүй талбайд орших ба маш жижиг байнгын бус дэд бүтэц одоогийн байдлаар төслийн талбай дээр байна. Компани нь эхлээд Баян Хөндий талбайг хөгжүүлэхээр (2020 оны сүүлээс эхлэн) төлөвлөж байгаа ба энэ талбайд боловсруулах үйлдвэр болон туслах дэд бүтцүүд байрших ба Алтан Нар талбайг дараа нь (2026 оны орчим) маш цөөн тооны байгууламжтай дагуул үйл ажиллагаа хэлбэрээр ашиглана. Төслийн барилгын үе шат нь 12 сар үргэлжилнэ гэж төлөвлөж байна. Тус төслийн олборлолтын хугацаа нь хаалтын шатны хамт 11 жил байна гэж тооцоолж байна. Уурхайн талбайн төлөвлөлт ба холбогдох дэд бүтцийн байршлыг доорх Зураг 3-т үзүүлсэн ба төслийн гол үзүүлэлтүүдийг Зураг 2-т танилцуулав.

#### Уурхайн үйл ажиллагаа:

- Төлөвлөж байгаагаар төсөл нь 11 жилийн настай, 600 мянган тон боловсруулах алтны ил уурхай юм. Уурхайд гидравлик экскаватор ашиглана. Өрөмдөж, тэсэлсэн материалыг ачааны машинаар зөөж, хаягдал чулуулгийг уурхайн амны хажууд орших инженерийн шийдэл бүхий Хаягдлын нэгдсэн байгууламжид (ХНБ) хадгалж, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийг Баян хөндийд байрлах боловсруулах үйлдвэрийн уурхайн амны хажууд орших боловсруулаагүй хүдрийн овоолгоны талбайд тээвэрлэнэ.

#### Боловсруулалт:

- Төслийн хүдэр боловсруулалтын зураг төслийн дагуу бол хүдрийг уурхайн амнаас олборлосон хүдэр байршуулах талбайд хадгална. Уурхайн амны овоолгоноос ирсэн хүдрийг нэг шатлалтай бутлуур түүний дараагаар нунтаглах дамжлагаар боловсруулна. Нунтаглах дамжлагаас гарсан бүтээгдэхүүнийг исэлдсэн хүдрийн идэвхижүүлсэн нүүрсэнд шингээж ялган авах уламжлалт аргаар боловсруулж алтыг угааж ялгах, электролизийн аргаар цэвэр алт гаргана. Хаягдлыг өтгөрүүлэгчээр дамжуулж ус болон реагентуудыг ялгаж авснаар хоргүйжүүлэх реагентуудыг багасгана. Хаягдлыг өтгөрүүлэгчээс гарсан урсацыг хоргүйжүүлж, шүүж улмаар уурхайн хаягдалтай хамт зайлуулахаар ачааны машигаар тээвэрлэнэ. Боловсруулах байгууламжууд нь захиргааны офисууд болон агуулах зэргийг мөн багтаана.

#### Хаягдлын нэгдсэн байгууламж:

- ХАТ нь ХНБ-ийг хаягдал чулуулаг болон үйлдвэрийн хаягдалд ашиглахаар төлөвлөж байна. ХНБ нь эрдсийн гаралтай хаягдлыг хамтад нь зайлуулснаар ул мөр багатай байх, хаягдлын бүтцийг бэхжүүлэх, улмаар урт хугацааны байгаль орчны эрсдэлийг багасгахаар зураг төслийг нь боловсруулсан.

#### Дуд бүтэц:

- Сүлжээнд холбогдоогүй дизель, болон нарны үүсгүүрээр уурхайн ойролцоогоор 6 МВт хүрэх суурь хэрэгцээг 7 хүртэлх тооны 1 МВт-ын генератороор хангахаар төлөвлөсөн. Түүнчлэн, ажилчдын кемпийн хэрэгцээг хангах 1МВт-ын дизель станц мөн төлөвлөсөн.
- Уурхайн кемп нь барилга болон үйл ажиллагааны үед ажилчдын сууц болох ба Баян хөндийн ил уурхайгаас хойд зүгт 4 км зайд байгуулахаар төлөвлөсөн. Ажилчдыг Баянхонгор аймгийн төв рүү онгоцоор тээвэрлэж, улмаар автобусаар төслийн талбайд авчирна. Шинэжинст болон Баян-Өндөр сумдын орон нутгийн ажилчид нь мөн төслийн талбайд автобусаар ирэх бөгөөд өөрсдийн ээлжийг дуусах бүрийд гэртээ автобусаар эргэж бусад үед төслийн талбайд оршин суух болно. Барилга болон үйл ажиллагааны үе шатанд бүх ажилчдыг ХАТ-ийн орон сууршлын кемп-д байлгах хандлагаар ажиллана.
- Уурхайн усны хэрэгцээг Баян хөндий ордоос баруун-урд зүгт 2-5 км зайд орших гүний усны давхаргаас нийлүүлнэ. Ус таталтын таван ширхэг цооног өрөмдсөн ба шахуурга болон уурхайн ус дамжуулах хоолой зэргийг барихаар төлөвлөөд байна. Ундны усыг төслийн талбай дээрх нөөц урвуу осмосын систем болон гаднаас савалсан ус зэргийг авч хангана.
- Баян хөндий болон Шинэжинст сумын хоорондын замын эвдрэл гэмлтийг засварлаж барилга болон үйл ажиллагааны үе гол ханган нийлүүлэх зам болгон ашиглана.

#### Ажиллах хүчин:

- ХАТ-ийн барилгын үе шат нь 12 сар хүртэл хугацаанд үргэлжилж туслан гүйцэтгэгч нарыг оролцуулаад нийт 506 хүний бүрэлдэхүүнтэй барилгын цомхон ажиллах хүчинтэй байх болно. Ашиглалтын үйл ажиллагааны үед Төсөл нь ойролцоогоор 337 хүнийг ажлын байраар хангана. Тус БОННУ-д болзошгүй нөлөөллийн үнэлгээний муу хувилбарын тооцоололыг оруулж нэмэлт 25%-ийн ажиллах хүчин буюу дээд тал нь нийт 421 хүний ажлын байрны нөөц тэтгэмжийг оруулж өгсөн. Ажиллах хүчин нь бүгд нэгэн зэрэг төслийн талбай дээр байхгүй ба ээлж тус бүрд илүү бага тооны ажилчид байх болно (дээд тал нь 190 хүн төслийн талбайд нэгэн зэрэг байна).

Зураг 2 Төслийн гол бүрэлдэхүүн хэсгүүд



**LEGEND**

Bayankhundii mining license area (MV-021444)	Sub-grade ore cell	Fuel storage	Road
Project buildings	Fenced landfill	Magazine and Detonator storage	Security fence
Open pit	Admin	Camp	
Processing plant	HV workshop	Laydown area	
Integrated waste facility	Power supply building	HV parking	
ROM pad			

Зураг 3 Хөндий Алтны төслийн талбайн зохион байгуулалт

## 2.2 Төслийн хувилбарууд

Төсөл нь олборлолтын арга, боловсруулах арга, технологи ба төслийн дэд бүтэц тухайлбал төслийн барилгын ажил эхлэх үед ашиглах замын сүлжээг авч үзсэн. “Төсөл хэрэгжүүлэхгүй байх” хувилбарыг авч үзсэн ба энэ нь ямар ч уурхай барьж ашиглахгүй байх хувилбар юм. ХАТ хэрэгжих хувилбарын хүрээнд байгаль орчин, нийгмийн зарим нөлөөлөл үүсэх ба голчлон орон нутгийн шинжтэй байна. Гэвч эдгээр нөлөөллөөс илүүтэйгээр ХАТ-ийн эерэг үр нөлөө нь орон нутаг ба үндэсний хэмжээнд илүү их байна гэж үзсэн.

ХАТ-ийн хүдрийг боловсруулах хэд хэдэн арга зүйг туршсан ба үүний үр дүнд ХАТ-ийн хүдрийг цианидаар уусган баяжуулах уламжлалт аргаар боловсруулахад хамгийн тохиромжтой гэж дүгнэсэн. Үүнд авч үзсэн бусад аргуудад нуруулдан уусган баяжуулах, гравитацийн аргаар ялгах мөн гравитаци- цианидын уусган баяжуулалтын хослол мөн Меррил- Кроу аргаар баяжуулах зэрэг багтсан. Эдгээр бусад хувилбаруудын дүнд үүсэх эрдсийн хаягдал түүний дотор цианидын хэрэглээ ба хаягдлыг зайлуулах асуудлуудыг мөн авч үзсэн. Хэрэгжих магадлалтай хэмээн тодорхойлсон бүхий л хувилбарууд эсхүл бага үр ашигтай, их зардалтай, ашиглалтын илүү хэцүү нөхцөлтэй, их концентрацтай, их хэмжээтэй янз бүрийн урвалж ашиглах шаардлагатай болон / буюу цианидын хэрэглээтэй тэнцүү буюу ихээр байгаль орчин, хүний эрүүл мэндэд эрсдэл учруулах хувилбарууд байв.

Дэд бүтцийн байршил ба зураг төслийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, ялангуяа аюулгүй ажиллагаа, тээврийн хэрэгслийн төрлийн ангиллыг харгалзан үзэж, газар хөндөлт болон хашаалалтыг бууруулах байдлаар, төслийн талбайн зонхилох салхи тоосжилт үүсгэхгүй, салхины эвдрэл үүсгэхгүй байхаар, явган хүний хөдөлгөөн, хур борооны урсцыг зайлуулах суваг шуудууг болзошгүй үерээс хамгаалж борооны ус цуглуулах зорилгоор ашиглах зэргийг харгалзан үзэж байршуулсан.

Цахилгаан эрчим хүчээр хангах хэд хэдэн хувилбарын судалгааг хийж Баян Хөндийг цахилгаан шугамтай холбох болон цахилгааны шугамгүйгээр эрчим хүчээр хангах хувилбаруудыг судалсан. Цахилгааны шугамтай холбохын тулд 110 км орчим урт 15 кВ шугам шаардлагатай боловч цахилгаан хангамж нь хүчдэлийн хэлбэлзэл ба тасалдал үүсгэх эрсдэл өндөртэй гэж үзсэн. Түүнчлэн цахилгаан шугам барих мөн шувуудад үзүүлж болзошгүй нөлөөллийг харгалзан үзэж төслийн талбай доторх цахилгаан үүсгүүрийг ХАТ-д ашиглахаар сонгосон.

ХАТ-ийн үйл ажиллагааны усан хангамжийг голчлон гүний усаар хангахаар төлөвлөсөн. Учир нь төслийн талбайд байнгын урсацтай гадаргын усны нөөц байхгүй. Түүнээс гадна, нийтийн ус хангамжийг ашиглах асуудал нь боломжгүй байсан учир нь төслийн талбайн алс хязгаар байршилтай ба орон нутагт нийтийн усан хангамжийн дэд бүтэц байхгүй. Төслийн талбайн усан хангамжийг Баян Хөндийн орд газраас ойролцоогоор 2-5 км зайд орших гүний усны цооногуудаас татах төлөвлөгөөтэй байна. Үүнээс өөр гүний усны эх үүсвэрийг илрүүлж судалсан ба энэ нь Баян Хөндийн ордоос баруун хойд зүгт ойролцоогоор 25 км зайд оршдог боловч холбогдох зардал ба үүнийг хөгжүүлэхийн тулд эвдрэлд орох газрын хэмжээ нь илүү ойролцоо усны эх үүсвэрийг ашигласнаас өндөр байв.

### 3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

#### 3.1 Үндэсний хууль тогтоомжийн шаардлагууд

Монгол улсын хууль тогтоомжийг сахин биелүүлэхээс гадна төслийн бүтээн байгуулалтын зарим зардлыг ЕСБХБ санхүүжүүлж буй учир ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлогыг (2014) дагаж мөрдөх шаардлагатай. Монгол улсын хууль тогтоомжид тусгасан тус төслийн дагаж мөрдөх гол байгаль орчин, нийгмийн шаардлагуудыг Байгаль орчны үнэлгээний тухай хууль (2012) ба Ашигт малтмалын хуулиар (2006) зохицуулдаг. Компани нь эдгээр хуулийн хүрээнд шаардсан төслийн байгаль орчны зөвшөөрлүүдийг Монгол улсын тусгай зөвшөөрөлтэй компаниар байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэсний дүнд олж авах явцдаа байна.

Нөлөөллийн үнэлгээний тайланд байгаль орчны хамгаалах, хяналт шинжилгээ хийх мөн төсөлтэй холбоотой үүсэх нөлөөллөөс зайлсхийх, бууруулах албан шаардлагууд багтсан байна. ЕСБХБ нь байгаль орчин, нийгмийн үнэлгээ ба хяналт шинжилгээний процессын дагуу өөрсдийн санхүүжүүлж буй төслүүд нь дараах зүйлсийг хангахыг зорьдог:

- Нийгмийн ба байгаль орчны тогтвортой байдал;
- Нөлөөлөлд өртөх ажилчид болон орон нутгийн хүмүүсийн эрхийг хүндэтгэх; мөн
- Холбогдох хууль тогтоомжийн шаардлагууд ба олон улсын сайн туршлагын дагуу төслийн боловсруулж үйл ажиллагаа явуулах.

Энэхүү зорилгыг практикт амжилттай үр дүн болгон хэрэгжүүлэхийн тулд ЕСБХБ нь тодорхой Гүйцэтгэлийн Шаардлагуудыг боловсруулж үүнийг нь санхүүжилт авагч тал хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн ба эдгээр нь байгаль орчин, нийгмийн гол нөлөөллүүд, асуудлуудыг авч үздэг. Тус төсөлд хамааралтай гүйцэтгэлийн шаардлагуудад дараах багтана:

- ГШ 1: Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлын үнэлгээ ба менежмент;
- ГШ 2: Хөдөлмөр ба ажиллах нөхцөл;
- ГШ 3: Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос сэргийлэх ба хянах;
- ГШ 4: Эрүүл мэнд аюулгүй ажиллагаа;
- ГШ 5: Газар чөлөөлөх, албадан нүүлгэн суурьшуулах ба эдийн засгийн хохирол амсах;
- ГШ 6: Биологийн олон янз байдлыг хадгалах, байгалийн амьд нөөцийг тогтвортой ашиглах;
- ГШ 8: Соёлын өв;
- ГШ 10: Мэдээллийг ил тод болгох, талуудын оролцоо.

## 4. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛҮҮД БА БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН ХУРААНГУЙ

### 4.1 Цаг уур ба агаарын чанар

#### 4.1.1 Өнөөгийн төлөв байдал

ХАТ-ийн талбайд бохирдол үүсгэгч эх үүсвэр байхгүй учир агаарын чанар нь ерөнхийдөө сайн. Зөвхөн хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй бохирдлын эх үүсвэрээс төслийн талбайд нөлөөлж буй жишээ дурдвал орон нутгийн зам ашигласнаас үүсэх тоос, тэр дундаа олон нийтийн тээвэр, ба орон нутгийн цаг агаарын нөхцөл байдалтай холбоотойгоор байгалийн жамаар салхиар боссон тоос шороо юм. Компани нь тогтмол агаарын чанарын хяналт шинжилгээг 2016 ба 2019 онд төслийн талбайд хийсэн ба үүний дүнд тоосжилтын түвшний талаарх ойлголттой болсон. Цуглуулсан мэдээнээс үзэхэд харьцангуй тогтсон хэмжээний хур бороо, агаарын температур, чийгшил, салхины хурд ба салхины чигтэй болох нь тогтоогдсон. Хур тунадас хамгийн бага унадаг үе нь аравдугаар сараас дөрөвдүгээр сарын хооронд тохионо. Харьцангуй чийгшил нь жилийн турш хуурай байна. Салхины дээд хурд дөрөвдүгээр сар ба арван нэгдүгээр сард тохиох ба зургаа/ долоо ба арван хоёр/ нэгдүгээр сард намуун төлөвтэй байна. Зонхилох салхи нь жилийн турш өмнөд-баруун ба баруун зүгээс салхилах ба энэ нь бохирдлын эх үүсвэрээс ялгарах бохирдол нь тухайн байршлынхаа зүүн хойд ба зүүн зүгт мэдрэгдэх магадлалтайг илтгэнэ.

#### 4.1.2 Нөлөөллүүд ба менежмент

Төслийн барилгын ба ашиглалтын үе шатанд агаарын чанарт нөлөөлж болзошгүй гол нөлөөллүүд нь тоосжилт үүсэх ба хийн бохирдлын ялгаралтай холбоотой. Агаарын чанарын нөлөөллийн мэдрэг хүлээн авагчид нь ажилчдын байрны ажилчид ба ХАТ-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай дотор орших малчдын өвөлжөө ба үүний хамгийн ойр нь 1.8 км зайд оршдог. Барилгын үе шатанд нөлөөллийн үргэлжлэх хугацаа нь богино хугацааны байх ба бохирдол ялгарах нь хязгаарлагдмал байна. Учир нь барилгын шатанд өрөмдлөг, тэсэлгээ, экскаватороор хутгах буюу бутлах үйл ажиллагаа байхгүй.

Уурхайн ашиглалтын шатанд үүсэж болзошгүй агаарын бохирдол нь төслийн талбайн хэмжээнд орон нутгийн шинжтэй байх ба тааламжгүй нөхцөл байдлын үед тус сөрөг нөлөөлөл ихсэх магадлалтай. ХАТ-ийн тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг маш бага хэмээн үнэлсэн ба учир нь уурхайн барилгын ба ашиглалтын үе шатанд цөөн тооны тээврийн хэрэгслийн хөдөлгөөн үүсэх юм. Нөлөөллийн үргэлжлэх хугацаа нь уурхайн ашиглалтын туршид үргэлжилнэ. Ашиглалтын шатны нөлөөллүүдээс эргэн сэргэх боломжтой, учир нь агаар мандлын орчин тухайн үйл ажиллагаа дуусмагц хуучин төлөвтөө очих боломжтой.

Боловсруулах үйлдвэрийн баруун урд байх малчдын өвөлжөөнд үзүүлж болзошгүй нөлөөллийг авч үзсэн. Тухайн тогтоосон өвөлжөө нь зөвхөн түр зуур хэдэн долоо хоног буюу сараар тухайн жилийн салхины тааламжтай (бага нөлөөтэй) нөхцөлтэй (уурхайн салхины дээр) үед эзэнтэй байдаг. Өвөлжөө эзэнтэй байх үед малчид уурхайн ашиглалтын үед агаарын чанарын тодорхой нөлөөнд өртөнө гэж үзсэн.

**Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Агаарын чанарын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд менежмент хийж тоосжилт үүсэхийг

бууруулах арга хэмжээнд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг сааруулах, овоолгын, тээврийн замын ба хөрсний элэгдлийн эх үүсвэрийн тоос шороог дарах, туузан тээвэрлэгч дээр мөн үйлдвэрийн төхөөрөмж дээр шүршигч ашиглах болон үйлдвэрийн тоног төхөөрөмжийг аль болох хаалттай орчинд байлгах аргууд багтана.

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ (тээвэрлэлтийн нөлөөлөл хэсгийг мөн үзнэ үү).

#### **Хяналт шинжилгээний шаардлагуудад дараах багтана:**

- Уурхайн талбай дээр байгаль орчны гол үзүүлэлтүүдийг хэмжиж хянах чадвартай цаг уурын хэмжих станц байгуулах.
- Тохиолдлын чанартай болон зорилтот агаарын чанарын хяналт шинжилгээний ажлуудыг шаардлагатай тохиолдолд бусад байршлуудад зориулалтын хөдөлгөөнт хяналт шинжилгээний нэгжийг ашиглан хийх.
- Байгууламжийн өмнө зүгт байх малчдын өвөлжөөнд эзэнтэй байх үед нь хяналт шинжилгээ хийх.
- Тоосжилт үүсэж буй эсэхийг нүдээр ажиглах ялангуяа барилгын үе шатанд, салхины хүч нэмэгдэх үед (жишээ нь хавар) мөн эвдрэл доройтолд орсон газруудад нөхөн сэргээлтийн хөтөлбөрийн үр дүнг сайжруулахын тулд хийх хэрэгтэй.
- Орчны агаарын чанарын хяналт шинжилгээг нөлөөлөл хүлээн авах цэгүүдэд холбогдох агаарын чанарын стандартуудын хүлцэх хэмжээг хэтрээгүй байх явдлыг хангахын тулд хэмжинэ.

## **4.2 Дуу чимээ ба чичиргээ**

### **4.2.1 Өнөөгийн төлөв байдал**

Төслийн талбай нь урьд нь аж үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт хийгдэж байгаагүй мөн ойр хавьд хүн амын суурингүй газар оршино. Судалгааны талбай доторх суурь судалгааны үеийн дуу чимээний түвшин нь Монгол улсын ба олон улсын стандартад заасан өдрийн цагт хүлцэх хэмжээний түвшнээс доор байсан. Судалгааны талбайн хэмжээнд чичиргээний талаар суурь мэдээлэл байхгүй боловч төслийн талбайн аливаа үйлдвэрлэл хөгжсөн газраас болон хүний суурьшлаас алс хязгаар газар оршдог байдаг учир чичирхийллийн түвшин байгалийн хэмжээндээ гэж үзэж болно.

### **4.2.2 Нөлөөллүүд ба менежмент**

ХАТ-ийн барилгын үе шатанд уурхайн гол болон туслах дэд бүтэц (жишээ нь хүдэр боловсруулах үйлдвэр, ажилчдын байр, оффис, ус хангамжийн шахуурга станц ба шугам хоолой, агуулах ба засварын газрууд гэх мэт) байгууламжуудыг Хөндийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд барилгын хүнд даацын машин, тоног төхөөрөмж ашиглан барина. ХАТ-ийн ашиглалтын үе шатанд ил уурхай, хүдэр ба хаягдал чулуулгийг уурхайн олборлосон чулуулаг дээр ялгахад мөн хаягдлын нэгдсэн байгууламж ба хүдэр боловсруулах үйлдвэр, дизель цахилгаан үүсгүүр зэрэг нь дуу чимээний гол эх үүсвэр байх болно. Энэхүү үнэлгээнд Баян Хөндийн ойролцоо орших малчдын түр бууцанд уурхайн дуу чимээнээс үзүүлэх нийт нөлөөлөл нь Төслийн стандартаас хэтрэхгүй ба дуу чимээний нөлөөлөл нь ялимгүй бага хэмээн дүгнэж байна. Алтан нар төслийн талбайд хамгийн ойр малчдын бууц нь мөн тус талбайн бүтээн байгуулалтаас үүсэх дуу чимээний нөлөөнд өртөхгүй гэдэг дүгнэлтэд хүрсэн.

ХАТ-д цөөн тооны тэсэлгээний ажлыг ашиглалтын оргил үед долоо хоногт гурав хүртэл удаа хийнэ. Тэсэлгээний ажлын үеийн дуу чимээний түвшин нь төслийн дуу чимээний түвшнээс давж болох боловч богино хугацаанд үргэлжлэх тул хүлцэх хэмжээний



хязгаарыг давах магадлал бага юм. Тиймээс зохих аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний дүнд тэсэлгээний ажлаас онц ноцтой нөлөөлөл үүсэхгүй гэж үзэж байна.

Төсөл нь Баян хөндий талбай ба Шинэжинст сумын хооронд хатуу хучилтгүй зам ашиглахаар төлөвлөсөн ба үүний тодорхой цэгүүдэд засвар үйлчилгээнд хамруулан уурхайн ашиглалтын үед хангамж нийлүүлэх гол зам болгон ашиглана. Томоохон зам барилгын ажил байхгүй учир замын засвартай холбоотой ажил ноцтой дуу чимээ, чичиргээний нөлөөлөл үүсэхгүй гэж үзэж байна.

**Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Дуу чимээ ба чичиргээний менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Боломжтой үед газар шорооны хүнд техник төхөөрөмжийн тоо хэмжээг зохицуулж нийт гарах дуу чимээний түвшнийг бууруулах.
- Дуу чимээ ба чичиргээг намдаах технологитой тоног төхөөрөмжийг аль болох сонгож ашиглах.
- Тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу тогтмол засвар үйлчилгээнд хамруулах.
- Хаана шаардлагатай болон боломжтой байна, тэр газар дуу чимээ үүсгэгч төхөөрөмжийг хүрээлэн дуу чимээ намдаах хашлага босгох.
- Тэсэлгээний хуваарийн талаар орон нутгийн иргэд ба ажилчдад урьдчилан мэдээлэх.

**Хяналт шинжилгээний шаардлагуудад дараах багтана:**

- Мэдрэг хүлээн авагч нарт дуу чимээний түвшин хэрхэн тусч байгаад хяналт шинжилгээ хийх мөн үүнийг тухайн нөлөөлөл ба эрсдэлийн түвшнийг харгалзан зохих давтамжтайгаар хийнэ.
- Дуу чимээ, чичиргээний өндөр түвшин бүхий ажлын байруудыг тухайн нөлөөлөл ба эрсдэлийн түвшнийг харгалзан тодорхой давтамжтайгаар хяналт шинжилгээнд хамруулах.
- Барилгын ба ашиглалтын үе шатанд их хэмжээний дуу чимээ ба чичиргээг үүсгэгч хөдөлгөөнд төхөөрөмж хэрэгслүүдэд байруудыг тухайн нөлөөлөл ба эрсдэлийн түвшнийг харгалзан тодорхой давтамжтайгаар хяналт шинжилгээнд хамруулах.

### 4.3 Газрын гадарга, ландшафт, геологи, хөрс ба газар хөдлөлт

#### 4.3.1 Өнөөгийн төлөв байдал

Төслийн талбайнуудад нөлөөлөлд мэдрэмтгий газрын тогтоц байхгүй ба ерөнхийдөө газрын гадарга болон ландшафтын төслийн нөлөөлөлд мэдрэг чанар бага гэж үзэж байна. Төслийн талбайн ойр орчимд тохиолдлын болон улирлын чанартай малаа бэлчээх малчид нь болзошгүй нөлөөллийн гол хүлээн авагчид болно. Байгаль орчны хувьд геологийн мэдрэмтгий байдал нь Төслийн барилга болон бүтээн байгуулалтын үе шатанд бага байна гэж тооцоолсон. Хөрсний бүтэц нь сайн бүрэлдээгүй ба энэ нь тачирхан ургамлын давхаргын доор бий болсон байна. Хөрс нь мөн байгалийн элэгдэл, хөлдөж хайлах зэрэг үзэгдэлд өртөмтгий болно. Төслийн талбайгаас цуглуулсан суурь мэдээлэл нь зарим байршлуудад байгалиасаа тохиолдох хүнд металл, хүнцэл болон молибденийн агууламж ихтэй байгааг харуулсан.

#### 4.3.2 Нөлөөллүүд ба менежмент

Барилгын ажил нь хөрсний нөөцөд зарим талын нөлөөлөл үзүүлэх ба хэдийгээр энэ нь бага зэрэг байхаар үнэлэгдсэн боловч тусгай зөвшөөрлийн талбайн 6%-ийг хамрах болно. Барилгын үе шатанд Төслийн хүрээнд баригдсан байнгын дэд бүтцийн ул мөрнөөс үүдэлтэй өнгөн хөрсийг хуулж, хадгалж, боломжтой тохиолдолд нөхөн сэргээлт, сэргээн засварлалтад ашиглана. Байнгын дэд бүтэц, барилгын доор орших хөрсний бүтэц нь төслийн ашиглалтын хугацаанд алдагдах болно. Үйл ажиллагааны үед хатуу хучилтгүй замаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хийснээр үргэлжилсэн хөрсний эвдрэл үүсэж болзошгүй. Гэсэн хэдий ч тээвэрлэлт нь зөвхөн зөвшөөрөгдсөн замналаар хийгдэж, жолооч нарт замгүй газраар явахыг хориглосон байх тул эдгээр нөлөө нь бага байх болно гэж тооцоолов.

ХНБ нь ХАТ-ийн үйл ажиллагаанаас үүдэх хамгийн том газрын гадаргын өөрчлөлт байх болно. ХНБ нь малчид болон авто замаар зорчигчдод харагдахуйц байх магадлалтай. Түүнээс гадна, уурхайн ам нь одоогийн байгаа газар орны төрхөд томоохон өөрчлөлт авчрах болно.

Уурхай нь олборлосон материалаа газрын гадаргад гаргах учир агаарт исэлдэх, улмаар хүчлийн урсац үүсгэх магадлалтай. Тус байгалийн үйл явцаар чулуулгийн сульфидууд агаар болон устай хүрэлцэж хүхрийн хүчил үүсгэх болно. Гэвч хүчил бий болох эрсдэл нь Баян хөндий ордын хувьд маш бага, Алтан нар ордын хувьд бага гэж тооцоолж байна.

#### **Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Газрын эвдрэл, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх.
- Хөрсний эвдрэлийг, тэр дундаа өнгөн хөрсний төлөвлөлт, хуулалт, хадгалалт, ашиглалтыг Өнгөн хөрстэй харьцах журам болон Газар хөндөх журам (ГХЖ) зэргийн дагуу зохицуулна.
- Авто зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, мөн түүнээс үүсэх тоос дарах, зам арчилгааны нөлөөллийг бууруулах зорилгоор Тээврийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. Замгүй газраар зорчих нь хориотой ба жолооч нар нь тэмдэглэгээ дээрх хурдны хязгаарыг мөрдөх шаардлагатай болно.
- Хөрсний бохирдолтой холбоотойгоор Аюултай материалын менежментийн төлөвлөгөө болон Хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх ба үүнд нь асгарсан бодисыг арилгах багц хэрэгсэл, хамгаалалтын хэрэгсэл, болон бусад шаардлагатай тоноглол төслийн талбай дээр байлгах болно.
- Бүх аюултай материалыг зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий гэрээт гүйцэтгэгчид тээвэрлэнэ. Хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий гэрээт гүйцэтгэгч нараас бусад тохиолдолд төслийн талбайгаас гадна орших газар цэвэрлэх эсвэл зайлуулахаар илгээхгүй. Эрдсийн гаралтай хог хаягдлыг тусгай зураг төслөөр хийгдсэн байгууламжид зайлуулна.
- Компани нь төслийн талбайн хаалт хийхээс өмнө бүхий л ухаж эвдрэлд оруулсан газрын нөхөн сэргээлтийг хийгдэнэ.

#### **Хяналт шинжилгээний шаардлагуудад дараах багтана:**

- ХАТ-ийн хүрээнд эвдрэлд орсон газрыг урьдчилан баталсан ГХЖ-ын дагуу тогтмол хянах.
- Өнгөн хөрсний овоолгын чанарын хяналт болон шинжилгээ хийх.
  - Бохирдол байгаа эсэхийг шалгах хөрсний чанарын шинжилгээ хийх.
  - Хэд хэдэн зам үүсээхээс сэргийлж замын нөхцөл байдлын үзлэг шалгалт хийх.
  - Эвдэрсэн газрыг аажмаар тухай бүр нь нөхөн сэргээх.


## 4.4 Ус

### 4.4.1 Өнөөгийн төлөв байдал

Төслийн талбай нь эх газрын Говийн цөлөрхөг бүсийн эрс тэрс уур амьсгалтай ба Монгол орны бусад хэсгийн адилаар жилийн дөрвөн улиралтай. Гадаргын ус хомс ба хүчтэй аадар борооны дараах түр зуурын урсгалтай голын түр зуурын урсцыг эс тооцвол, усны нөөц нь цөөн тооны алслагдмал орших горхиор хязгаарлагдана. Гадаргад ойр гүний ус нь малчид болон мал амьтны усны уламжлалт гол эх үүсвэр байсаар ирсэн бөгөөд гадаргад ойр хэсэгтээ том зэрлэг амьтад мөн ундаална. Тус гадаргад ойр гүний ус нь орон нутагтаа хэсэгчлэн ургах гүний уснаас хамааралтай ургамлыг мөн тэтгэнэ.

Төслийн усны хэрэгцээг Хүрэн цав (ХЦ) болон Босгын сайр (БС) цооногуудын талбайгаас, Алтайн өвөр говийн террейны хагас болон бүрэн түрэлтэт уст давхаргаас хангана. Төлөвлөж буй цооногууд нь шаардлагатай усны хэрэгцээг хангана гэж үзэж байна. Урьдчилсан зураг төслийн усны хэрэгцээ нь 11 л/с хэмжээтэй байна хэмээн тооцон хийсэн ба энэ нь шаардагдах усны муу (ус их хэрэглэх) хувилбар нь юм.

Баян хөндийн (БХ) судалгаанд хамрагдсан талбайд малчид нь тун сийрэг бөгөөд улирлын чанартай оршин суух ба энэ нь Говь цөлийн хур тунадас багатай бүс нутагт байрладагтай холбоотой. БХ нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн 5 км радиус дотор Майхан хүрэн (зэргэлдээ орших 2) болон Хүрэн цав гэсэн гурван малчдын худагтай. Голын хатсан татам болон малчдын худгаас авсан дээжийн усны чанарын үзүүлэлт нь холбогдох стандартыг давсан хүнд металлын агууламжтайг үзүүлсэн ба газар хөндөхөөс өмнөх үеийн хүнд металлын агууламж нь бүс нутагт их байхыг харуулсан болно.



Зураг 4. Хөндий Алтны төслийн талбайн ойролцоох худгуудийн байршил

Алтан нар талбайн хувьд малчин өрхүүд нь сийрэг бөгөөд улирлын чанартай оршин суудаг нь Говь цөлийн бүс, хур тунадас багатай байдагтай холбоотой. Алтан Нар нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн 5 км радиус дотор орших Сүүн толгой,

Хоолой худаг хэмээх тусгай зөвшөөрлийн талбайн хилтэй ойр байрлах хоёр худаг зэргийг багтаасан нийт гурван усны худагтай. (Зураг 4).

#### 4.5 Нөлөөлөл ба менежмент

Усны нөөцөд дараах гол нөлөөллүүд нөлөөлнө:

- Ус ашиглалттай холбоотой нөлөөллүүд;
- Гадаргын ба гүний усны нөөц ба чанарт үзүүлэх нөлөөллүүд; мөн
- Гадаргын усны горимд үзүүлэх нөлөөллүүд юм.

ХАТ-ийн дэд бүтцийн барилгын ажлын явцад үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх нөлөөлөл нь зөвхөн төслийн талбайд барилгын ажил үргэлжлэх хугацаанд тохионо гэж үзсэн. Барилгын ажил нь харьцангуй бага хэмжээний усыг богино хугацаанд ашиглах тул нөлөөллийн цар хэмжээг маш бага гэж үзсэн. Төслийн усан хангамжийг гүний ус олборлолтоор хангах тул байгаль орчны нөлөөлөл ашиглалтын үед гарч болно гэж үзэж байна. Малчдын худаг ба усны хэрэглээг үнэлгээнд авч үзсэн ба менежментийн болоод сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг доор дэлгэрүүлж тайлбарлав.

#### Гүний ус:

Төслийн усан хангамжийг гүний ус олборлож хангах тул байгаль орчны нөлөөлөл үүсэж болзошгүй. ХАТ-ийн үйл ажиллагааны явцад гүний ус олборлосноос үүсэж болзошгүй аливаа нөлөөллийг бууруулах гол арга нь усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх явдал юм. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол арга нь цооногийн хяналт шинжилгээ хийх хөтөлбөр юм. Компани өөрийн нөлөөллийн бүс доторх гүний усны асуудлуудад хяналт шинжилгээг хийж эхлээд байгаа боловч илүү эрчимтэй нарийн хяналт шинжилгээг ХАТ-ийн барилга ба ашиглалтын үе шат эхлэхээс өмнө хийх болно. Энэ хугацаанд цуглуулах нэмэлт суурь тоо мэдээ нь гүний усны түвшний улирлын чанартай байгалийн хэлбэлзлийн талаарх нэмэлт ойлголтыг өгнө. Эдгээр мэдээлэл нь Хүрэн цав ба Босгын сайрын цооног ашиглалтын нөлөөлөл гидрогеологийн горим болон малчдын худагт хэрхэн нөлөөлж буйг үнэлэх үнэлгээнд нэмэлт мэдээлэл болж өгнө. Гүний усны хяналт шинжилгээний ажлын зорилго бол байгалийн жамаар үүсэх өөрчлөлтөөс гадна гүний усны татах үйл ажиллагаатай холбоотой үүсэх нөлөөллийг тодорхойлох явдал юм.

Газрын доорх гүний усны хяналт шинжилгээ нь тодорхой хугацаанд хийгдэх усны түвшний хэмжилт, ус таталтын түвшний хяналт мониторинг мөн гүний усны цооногоос дээж авах ажлуудаас тогтоно. Гүний усны хяналт шинжилгээний хөтөлбөр нь гол оролцогч талуудын оролцоог хангасан хөтөлбөр байх ба багийн иргэд болон орон нутгийн удирдлагуудын тодорхой төлөөллүүдийг оролцуулах болно. Эдгээр хяналт шинжилгээний ажил нь усны түвшин буурсан аливаа тохиолдлыг үнэлэх мөн усны чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох дээж авах мөн гүний ус таталттай холбоотойгоор үүссэн байж болзошгүй аливаа нөлөөлөлд шинжилгээ хийж усны ерөнхий химийн төлөв байдлыг үнэлэх боломж олгоно. Хяналт шинжилгээний явцад шалгуур үзүүлэлтүүдийг давсан тохиолдол илэрвэл тухайн нөлөөллийг бууруулах хариу арга хэмжээг авах болно. Хариу арга хэмжээнд ус шахуургадан гаргах түвшнийг тухайн ус хангамжийн цооногт өөрчлөх ажил орж болно. Мөн Хүрэн цав ба Босгын сайрын цооногуудыг ашиглаж эхлэхээс өмнө усны хүртээмж ямар байсан тэр хэмжээнд малчдын усан хангамжийг хадгалахын тулд малчдад тусламж дэмжлэг эсхүл тодорхой дэд бүтцээр хангах асуудлыг компани авч үзнэ. Хэрэв төслийн хүрээнд гүний ус татах ажил одоо буй малчдын худгийн усан хангамжид нөлөөлбөл

ашиглах зорилгоор нөөц усны цооногийг Хүрэн цавын ус агуулагч талбайд байршуулсан ба энэ нь малчдын усан хангамжид шаардлагатай тохиолдолд нэмэр болох юм.

#### Гадаргын ус:

ХАТ-ийн талбайн байгууламж ба дэд бүтэц нь гидрологийн байгалийн горимд нөлөөлж болзошгүй ба төслийн талбайн урсцын налуугийн доор орших газрын гадаргын усны урсцыг өөрчилж болох юм. Нөлөөллийг дараах арга хэмжээнүүд болон бусад арга хэмжээнүүдийн хамтаар хэрэгжүүлснээр бууруулах болно:

- Дэд бүтцийн зураг төслийг зохиохдоо байгалийн урсцын голдрилтой аль болох бага огтлолцохоор төлөвлөнө
- Шаардлагатай үед замын хөвөөгөөр ус зайлуулах суваг хийж борооны дараах гадаргын урсцыг тогтоон барьж орон нутгийн гидрологийн үндсэн төлөв байдлыг хадгална.
- Хүчтэй хур борооны дараах урсцыг үйл ажиллагааны талбайгаас зайлуулж урсцын налуугийн дагуух байгалийн голдиролд нь элэгдэл эвдрэл үүсгэхгүй нэмэлт седимент тунадас үүсгэхгүй байх аргаар нийлүүлнэ.

#### Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:

- Усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг (УНМТ) боловсруулж хэрэгжүүлнэ.
- Усны хяналт шинжилгээний төлөвлөгөөг (УХШТ) боловсруулж хэрэгжүүлнэ.

#### Хяналт шинжилгээний шаардлагуудад дараах багтана:

- УНМТ ба УХШТ-ний процессд Хүрэн цав ба Босгын сайрын цооногуудаас татах гүний усны эзлэхүүн хэмжээг бүртгэх мөн олборлосон усны эзлэхүүн хэмжээг зураг төсөлд тусгасан хяналтын хэмжээтэй харьцуулан үнэлэх мөн гүний усны түвшний хяналт шинжилгээг зохих байршлуудад хийж төслийн стандарт хүлцэх түвшинтэй харьцуулан үнэлэх.
- Гүний усны түвшний тогтвортой өөрчлөлт (нэмэгдэх эсхүл буурах) явдал хяналтын цооногуудад ажиглагдвал цааш нэмэлт үнэлгээг хийх шаардлагын дохио болно. Түүнчлэн гүний усны түвшний талаарх гомдол санал ирсэн тохиолдолд нэмэлт үнэлгээг хийнэ.

## 4.6 Биологийн олон янз байдлын хамгаалал

### 4.6.1 Өнөөгийн төлөв байдал

Төслийн талбайн экологийг авч үзвэл цөл, хээрийн ургамалжилттай ба энэ нь Монгол орны өмнө Говийн бүсийн түгээмэл хэв шинж бөгөөд биологийн олон янз байдлын өндөр үнэ цэнэ бүхий зарим зүйлүүд үүнд багтана. Хууль тогтоомжид заасны дагуу нийт есөн зүйлийн “ховор” буюу “нэн ховор” ургамлууд ХАТ-ийн ойр орчимд тэмдэглэгдсэн. Амьтны аймгийн зүйлүүд нь энэ бүс нутагтаа түгээмэл амьтад байв. Судалгааны явцад найман зүйл хөхтөн амьтан бүртгэгдсэн. Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) Монголын улаан дансанд эмзэг зүйл амьтан гэж тэмдэглэгдсэн Хар сүүлт зээр судалгааны явцад ажиглагдсан ба энэ бүс нутаг нь тус зүйл амьтны тархац нутагт багтдаг. Мөлхөгчдийн олон янз байдал харьцангуй ядмаг боловч мөлхөгчдийн тохиолдоц элбэг. Эдгээр амьтад нь махчин шувууд ба хөхтөн амьтад хоол тэжээлийн чухал эх үүсвэр болж өгдөг. Нийт зургаан мөлхөгч амьтад тэмдэглэгдсэнээс нарийн могой ба Говийн махир хуруут гүрвэлийг Монгол улсын хуульд “ховор” амьтан гэж заасан. Шувуудын

биологийн олон янз байдал харьцангуй арвин буюу 23 зүйл ажиглагдсан ба ихэнх нь түгээмэл зүйлүүд байсан. Жороо тоодог ба Монгол хулан жороо хоёрыг Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) Монголын улаан дансанд зааснаар байгаль хамгааллын өндөр үнэ цэнэтэй амьтад болохыг тодорхойлсон. Төслийн ойр орчимд шувуудад чухал гэх талбай байхгүй.

#### 4.6.2 Нөлөөллүүд ба менежмент

**Ургамлын аймаг:** Барилгын ба ашиглалтын үйл ажиллагаанууд нь газар ухах, хөрс нягтаршуулах буюу өөрчлөх замаар амьдрах орчинд шууд нөлөөлөх боломжтой ба энэ нь ургамлын бүрхэвч санамсаргүйгээр аюултай бодис асгарч хөрс бохирдсоны улмаас алдагдахад хүргэж болно.

**Амьтны аймаг:** Барилгын ба ашиглалтын үйл ажиллагаануудаас хөхтөн амьтдын зүйлүүдэд үзүүлж болзошгүй нөлөөлөл нь голчлон уурхайн талбай дээр хүн байрших болон барилгын материалын тээвэрлэлттэй холбоотойгоор амьдрах орчноос дайжих асуудал юм. Хар сүүлт зээр болон эрээн хүрнэтэй машин санамсаргүй мөргөлдөхөөс бусад шууд нөлөөлөл байхгүй гэж үзэж байна. Гэвч барилгын ажлын үргэлжлэх хугацаа дээд тал нь 12 сар байх мөн уурхайн шууд ул мөр нь хөхтөн амьтдын тархац нутагтай харьцуулахад жижиг юм. Тиймээс хөхтөн амьтад үзүүлэх нөлөөллийг тус судалгаанд ялимгүй бага буюу бага гэж үнэллээ.

**Шувууд:** Төслөөс шувуудад үзүүлэх нөлөөллүүд нь барилгын ажилтай холбоотой үүсэх нөлөөллүүд ба газарт үүрлэдэг элбэг шувуудын үүр сүйдэх мөн барилгын шатны сүүл болон ашиглалтын шатанд цахилгаан түгээх шугамд цохиулах зэргээр хязгаарлагдана. Тухайн зүйл шувуудын тархацын нутагтай харьцуулахад төслийн талбай нь жижиг бөгөөд цахилгаан дамжуулах шугам төслийн талбай дотор байх тул ХАТ-өөс нөлөөлөлд мэдрэг шувуудын зүйлүүдэд үзүүлэх нөлөөллийн цар хэмжээг маш бага гэж дүгнэв.

**Мөлхөгчид:** ХАТ-ийн ул мөр ба нөлөөллийн талбай нь нөлөөлөлд мэдрэг мөлхөгчдийн тархац нутгаар давхцана. Тиймээс уурхайн бүтээн байгуулалт газар хөндөлт хийсэнтэй холбоотойгоор амьтдын амьдрах орчинд шууд нөлөөлж болно. Санамсаргүй машинд дайруулж хорогдох нөлөөлөл гарч болзошгүй.

**Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөллүүд:** ХАТ-ийн төслийн талбайд хамгийн ойр тусгай хамгаалалттай газрууд: Говийн их дархан цаазат газрын А хэсэг (зүүн урд зүгт 27 км), Говь гурван сайхан байгалийн цогцолборт газар (зүүн зүгт 48 км), Тост тосон бумбын байгалийн нөөц газар (зүүн урд зүгт 70 км) юм. ХАТ-ийн барилгын ба ашиглалтын үйл ажиллагаатай холбоотойгоор тусгай хамгаалалттай газруудад үүсэж болзошгүй нөлөөллүүдийг дурдвал барилгын ажилтай холбоотойгоор Говь гурван сайхны байгалийн цогцолборт газраар дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн тоо бага хэмжээгээр нэмэгдэх явдал юм. Эдгээр нөлөөллүүд нь ялимгүй бага гэж үзсэн учир нь барилгын үе шатанд цөөн тооны машин богино хугацаагаар явна. Тээвэрлэлтийг тусгай хамгаалалттай газар дотор одоо ашиглагдаж буй замыг ашиглан шинэ зам үүсгэхгүйгээр явуулна. Шинэжинст сумаас төслийн талбай хүрэх зам нь ямар ч тусгай хамгаалалттай газраар дайрахгүй.

#### **Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Бүхий л тохиолдолд төсөл нь газар хөндөх зөвшөөрлийн журмыг тухайн газар шорооны ажил хийх гэж буй талбайд хэрэгжүүлнэ.

- Түр зуурын эвдрэл доройтолд орох газрын нөхөн сэргээлт ба дахин ургамалжуулалтыг төслийн барилгын ажилтай уялдуулан аль болох зохих хэмжээнд нь хийж гүйцэтгэнэ.
- Тээврийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж тээврийн хэрэгслийн зам дагуух хөдөлгөөнөөс тэр дундаа тоос дарах ба зам засварын ажлаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор хэрэгжүүлнэ. Замаас гадуурх хөдөлгөөнийг хорьж бүх жолооч нарт хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээг дагаж мөрдөхийг үүрэг болгоно.
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим болон зэрлэг амьтан зам хөндлөн гарч болзошгүй хэсгүүдэд хяналт мониторинг хийж аливаа замын осол гарсан мэдээг тэмдэглэж бүртгэнэ.

#### **Хяналт шинжилгээний шаардлагуудад дараах багтана:**

- Барилгын ажил эхлэхээс өмнөх судалгааг аливаа хөндөлт эвдрэл доройтлоос өмнө хийж гүйцэтгэнэ;
- Цахилгааны шугам дагуу сар бүр ажиглалт шалгалт хийж шувуу цахилгаанд цохиулж үхэж хорогдсон эсэхийг тайлагнана;
- Улирал тутам нэн тэргүүний ач холбогдол бүхий хөхтөн амьтад ба бусад зүйлүүдийн хяналт шинжилгээг хийж
- Жил бүрийн ургамлын аймгийн хяналт шинжилгээний ажлыг хийнэ.

## 4.7 Хог хаягдал

### 4.7.1 Өнөөгийн төлөв байдал

Төслийн улирлын чанартай хайгуулын болон техникийн хээрийн хөтөлбөрийн үйл ажиллагаанууд нь ХАТ талбайд бага хэмжээний ахуйн хог хаягдал бий болгоно. Тус бага хэмжээтэй, аюулгүй хог хаягдлыг зөвшөөрөл бүхий, инженерийн шийдэлгүй энгийн дарж булж устгах цэгт зайлуулдаг. Дахин ашиглах үйл ажиллагаа нь хуванцар савыг цуглуулж Улаанбаатар хот руу дахин боловсруулахаар илгээхээс бүрдэнэ. Түүнчлэн, Компани нь төслийн талбай дээр хүнсний хог хаягдлаар бордоо үйлдвэрлэх туршилт хийсэн.

### 4.7.2 Нөлөөлөл ба менежмент

Төслийн хэрэгжилтийн хамтаар материалын хэрэглээ болон хог хаягдлын ялгарал зэрэг явагдах болно. Барилга болон ашиглалтын үйл ажиллагааны үед аюулгүй болон аюултай хог хаягдал хоёул ялгарах болно. Эдгээр нь доорх төрлийн байх төлөвтэй байна:

- Ахуйн хог хаягдал,
- Аюултай бус, үйлдвэрийн хог хаягдал (торх, дугуй, хаягдал металл гм),
- Аюултай үйлдвэрийн хог хаягдал (хаягдал нүүрстөрөгчийн тос, ашигласан тос, химийн бодисын савлагаа, тостой даавуу, зай хураагуур, будаг),
- Эмнэлгийн болон лабораторийн хаягдал, мөн
- Хаягдал ус.

Төсөл нь ахуйн болон аюулгүй хог хаягдлыг газарт булж зайлуулах, инженерийн шийдэл бүхий ландфил байгуулахаар төлөвлөж байна. Бүх боломжит аюултай хог хаягдлыг цуглуулж, зохих, тусгай зөвшөөрөл бүхий дахин боловсруулах эсвэл зайлуулах байгууламж руу тээвэрлэх хүртэл аюулгүй байдлаар хадгална. Тусгай зориулалтын хаягдал ус цэвэрлэх байгууламжийг үндэсний стандартад нийцүүлэн хаягдал усыг цэвэршүүлэхэд зориулан барьж байгуулна. Доор санал болгосон нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр, хог хаягдалтай холбоотой нийт нөлөөлөл нь ялимгүй багаас бага байна гэж үзсэн.

Эрдсийн хог хаягдлын менежментийн хувьд Компани нь хаягдал чулуулаг болон үйлдвэрийн шүүсэн хог хаягдлыг холих цогц шийдлийг санал болгож байгаа юм. Энэ арга нь Хаягдлын нэгдсэн байгууламжид хаягдал чулуулаг болон хатааж, шүүсэн үйлдвэрийн хаягдлыг холих арга юм. Тус “холих” үйл явц нь чулуулгийн хоорондын хоосон зайг үйлдвэрийн хаягдлаар сайтар чигчилж өгдгөөр онцлог ба байж болох хамгийн бат бөх бүтэцтэй газарт булах биет бий болгоно. Хаягдал чулуулагт үйлдвэрийн хаягдлыг нэмснээр нэвчих байдлыг багасгаж, хүчиллэг урсац болон металл уусгалт үүсгэхэд хүргэдэг хүчил төрөгч нэвтэрч харилцан үйлчлэх эрсдэлийг багасгана. Улмаар, ХНБ нь ХАТ-ийн хувьд хог хаягдлын менежментийн хамгийн аюулгүй бөгөөд үр ашигтай арга гэж тооцогдож буй юм. Хаягдал чулуулагт хүчил үүсэх боломж багатайг харгалзан үзэхэд, тус холимог материал нь бохирдуулагч бодис ялгаруулах магадлал багатай юм.

**Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Аюултай материал болон хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх.
- Аливаа аюултай хог хаягдлыг төслийн талбайд газарт булахгүй ба бүхий л аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий хог хаягдлын байгууламж руу тээвэрлэх болно.
- Хог хаягдлыг зайлуулах ажлын менежмент нь ихэвчлэн хог хаягдал ялгаруулалтыг багасгах, дахин боловсруулах болон зохих ёсоор зайлуулах зэргээр хэрэгжинэ.
- Төслийн талбайд бий болсон аюултай бус хог хаягдлыг төслийн талбай дээрх цэгт газар булах.
- Харьцах, хадгалах, боловсруулах болон зайлуулахад дөхөм болгох үүднээс хог хаягдлыг төрлөөр нь ангилах болно. Эдгээрийг үндэсний стандарт болон олон улсын удирдамжийн дагуу ангилах болно.
- Хог хаягдлын бүртгэлийг сар бүр ялгаруулсан хэмжээг оролцуулан хөтөлнө.
- Боломжтой үед, мод, дугуй, хаягдал металл, картон зэрэг дахин ашиглах боломжтой материалуудыг оролцогч талуудтай зөвшилцсөний үндсэн дээр ашиглахад нээлттэй байлгах болно.
- Хаягдал ус цэвэрлэх байгууламжийг суурилуулж ашиглалтад оруулна.
- Байгальд нийлүүлэх эсвэл тоос дарах зорилгоор ашиглахын өмнө хаягдал усыг үндэсний стандартын дагуу цэвэршүүлнэ.

**Хяналт шинжилгээний шаардлагуудад дараах багтана:**

Хог булах цэг, ХНБ зэрэг бохирдол үүсэх боломжтой бүх газарт хөрсний болон гүний усны чанарын шинжилгээний хөтөлбөрийг бий болгоно.

## 4.8 Хүн ам зүй

### 4.8.1 Одоогийн нөхцөл байдал

2018 оны эцсийн байдлаар Баянхонгор аймгийн хүн амын тоо 88,359, нийт өрх 26,300 бүртгэгдсэн байна. Аймгийн хэмжээнд сумын төв болон аймгийн хойд хэсэгт хүн ам төвлөрөн суурьшдаг. Баянхонгор аймгийн төвд аймгийн нийт хүн амын 35 хувь нь оршин суудаг. Аймгийн хэмжээнд гадагш болон дотогш чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн бага байдаг. Баян-Өндөр сум нь аймагтаа нутаг дэвсгэрийн хэмжээгээр хамгийн том сум бөгөөд Шинэжинст сум түүний дараа хоёрдугаарт ордог байна. Тус сумд нь Баянхонгор аймгийн хамгийн өмнөд хэсэгт байрладаг бөгөөд аймгийн хэмжээнд хүн амын хамгийн сийрэг суурьшилтай сумд юм. 2019 оны байдлаар Шинэжинст суманд нийт 2449 хүн, 754 өрх бүртгэгдсэн бол Баян-Өндөр суманд нийт 2668 хүн, 753 өрх бүртгэгдсэн байна. Багийн



хэмжээнд Шинэжинст сумын Уртын гол багт 902 хүн, 267 өрх, Баян-Өндөр сумын Идрэн багт 433 хүн, 112 өрх тус тус бүртгэгдсэн байна.

Өрхийн судалгаанд оролцогчдын 99% нь боловсролтой гэсэн бол 1% нь бичиг үсэггүй, боловсролгүй гэж хариулжээ. Нийт судалгаанд хамрагдсан өрхүүдээс 10% нь бага боловсролтой, 25% нь дунд боловсролтой (6-9 дүгээр анги дүүргэсэн), 39% нь бүрэн дунд боловсролтой, 8% нь мэргэшсэн ба үлдсэн 16% нь дээд боловсролтой гэж хариулсан байна. Баян-Өндөр болон Шинэжинст сумд нь хүн амын төвлөрөл багатай бөгөөд 9 дүгээр ангийн боловсрол олгох сургуулиас цааш үргэлжлүүлэн боловсрол олгох сургууль байдаггүй. Тус сумдад тулгамдаж буй чухал асуудлуудын нэг нь залуучуудад боловсрол олгох, тэдгээрийг эдийн засгийн боломжоор хангах явдал юм. Хоёр сумдын хувьд 10-аас доош насны хүүхдүүд болон 10-29 нас хүртэлх насны залуучууд нийт хүн амын томоохон хувийг бүрдүүлдэг бөгөөд залуучуудын хувьд ажилгүйдлийн түвшин өндөр мөн сумын хэмжээнд хөгжил дутмагаас боломж бага байдаг талаар санаа зовниж буйгаа өрхийн судалгаанд оролцогчид илэрхийлсэн байна.

#### 4.8.2 Нөлөөлөл болон менежмент

ХАТ-ийн бүтээн байгуулалтын үр дүнд Шинэжинст болон Баян-Өндөр сумдын (сумын төвүүдэд) оршин суугчид болон хоёр сумдын сургууль, эмнэлгүүдэд (ажилтнууд болон хэрэглэгчдэд) бага хэмжээний нөлөөлөл үүсэж болзошгүй байна. Компани нь нутгийн ард иргэдэд үүсэж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх тул эдгээр үүсэх нөлөөллийн хэмжээ нь “Бага” байх төлөвтэй байна.

#### **Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Ажилчдыг уурхайн талбай дээр байршуулснаар орон нутгийн суурин газруудад үүсэх шилжилт хөдөлгөөнийг багасгах;
- Ажилчдыг уурхайн талбайд шаардлагатай үйлчилгээ болон байгууламжаар хангаж (эрүүл мэндийн үйлчилгээ, г.м) бүс нутгийн хэмжээнд нэмэгдэж болзошгүй ачааллыг бууруулах.
- Төслийн нийгмийн нөлөөллийн бүсэд жөндөрт суурилсан хүчирхийлэл болон ажлын байран дахь дарамт шахалттай холбоотой эрсдэлүүдийг бууруулах зорилгоор ажилчдын дагаж мөрдөх ёс зүйн дүрэм, дарамт шахалтын талаар баримтлах бодлого зэргийг хэрэгжүүлэх.
- Орон нутагт тодорхой хугацаанд оршин суусан нотолгоо, оршин суугчийн бүртгэл зэрэг орон нутгаас ажилд авах шаардлагыг хангахад анхаарах. Энэхүү шаардлагуудыг нутгийн захиргааны газар, агентлагуудад мэдээлж, орон нутагт чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах.
- Хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой сөрөг нөлөөллүүд, төслийн ажилчид болон ард иргэдийн хоорондын харилцаа холбоо зэрэгт сумын захиргаатай хамтран хяналт шинжилгээ хийх. Шаардлагатай тохиолдолд зохих арга хэмжээг авч ажиллах.
- Туслан гүйцэтгэгч байгууллагуудын ажилчдыг ХАТ-ийн шаардлагуудыг даган мөрдөж ажиллахыг шаардах. Үүний дагуу барилга угсралтын болон үйл ажиллагааны үе шатанд орон нутгийн хэмжээнд үр ашигт байдлыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн иргэдийг ажилд авах тал дээр ач холбогдол өгч, олон нийтийн эрүүл мэндийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны шаардлага хангаж ажиллах.
- Нутгийн захиргаа болон төсөл хэрэгжүүлэгчийн хамтын ажиллагаанд төслөөс шилжилт хөдөлгөөн нэмэгдэхтэй холбоотой зохицуулалт хийх хуулийн заалтуудыг багтаасан байна. Компанийн зүгээс шаардлагатай тохиолдолд төслөөс үүсэх аливаа нийгмийн асуудлыг зохицуулахад холбогдох захиргааны байгууллага, цагдаагийн газартай

хамтран ажиллах.

## 4.9 Эдийн засаг болон ажил эрхлэлт

### 4.9.1 Одоогийн нөхцөл байдал

Сумын түвшинд авч үзэхэд, Шинэжинст суманд эдийн засгийн идэвхтэй 1,381 хүн ам бүртгэлтэй бол Баян-Өндөр суманд 1,685 идэвхтэй хүн ам бүртгэлтэй байна. Хоёр сумдад хөдөлмөрийн насны хүн амын дийлэнх нь хөдөө аж ахуйн салбарт, голдуу мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байна. Төсөл хэрэгжих газарт мал аж ахуй зонхилдог. 2019 онд Шинэжинст суманд идэвхтэй 28 аж ахуй нэгж, Баян-Өндөр суманд 18 аж ахуй нэгжүүд талх, нарийн боовны дэлгүүр, барилгын блок үйлдвэрлэл, гурилын дэлгүүр, кафе, гэр ахуйн модон тавилга, оёдлын цех, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байна. Баянхонгор аймгийн төвд бетон зуурмаг, худалдаа, хотын усан хангамж, эрчим хүчний системийн менежмент, барилга угсралт зэрэг жижиг хэмжээний үйлдвэрлэл хөгжсөн байна.

Орон нутгийн ард иргэдийн дунд уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой гэж үзсэн сөрөг нөлөөллүүдэд газар ашиглалтын зориулалт өөрчлөгдөх, газрын бүтээмжийг буурах, усны нөөцийн хэрэглээ, агаарын чанар доройтох, тоосжилт үүсэх зэрэг багтаж байна. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой эерэг нөлөөллүүдэд орон нутгийн эдийн засгийг сайжруулах, орон нутгийн зах зээлд шинээр ажлын байр бий болох зэрэг багтаж байна. Сумын захиргаа, аж ахуй нэгжүүд, эдийн засгийн идэвхтэй бөгөөд хөдөлмөрийн насны гишүүдтэй өрх айлуудын дунд компаниас ихээхэн хүлээлт үүссэн ба ХАТ нь сумын иргэдэд ажлын байрыг бий болгоно гэсэн хүлээлттэй байна. Сумын түвшинд боловсон хүчний ур чадвар дутмаг байгааг орон нутгийн иргэд хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд шинээр үүсэх ажлын боломжуудад нэмэлт сургалт, ур чадварыг хөгжүүлэх шаардлагатай гэсэн ойлголттой байна.

### 4.9.2 Нөлөөлөл болон менежмент

Төслийн барилга угсралтын болон үйл ажиллагааны үе шатанд үүсэх нөлөөллийн эх үүсвэрүүд нь шууд болон шууд бус ажил эрхлэлт, ашигт малтмал ашигласны төлбөр, төсөлтэй холбоотой татвар, хураамж, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалт зэрэг багтана. Үүнээс гадна, шууд бус ажил эрхлэлт болон бизнесийн боломжууд бий болох бөгөөд хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.

#### **Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

Хүний нөөцийн менежментийн төлөвлөгөө (ХНМТ), Орон нутгийн хамтын ажиллагааны менежментийн төлөвлөгөө, Оролцогч талуудын болон харилцаа холбооны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. Тэдгээрт үр ашигтай нөлөөллийг бий болгох зорилгоор дараах заалтуудыг тусгана.

- Орон нутгийн боловсон хүчний ур чадвар, боловсролын түвшинг харгалзан авч үзэх; сургалт хөгжүүлэлтийг хийх гүйцэтгэх орон нутгийн боловсролын байгууллагуудын хүчин чадлыг харгалзан авч үзэх; сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн боловсролын байгууллагуудад тусламж дэмжлэг үзүүлэх.
- Ажилчид болон туслан гүйцэтгэгчдэд сургалт зохион байгуулж, ХАТ-ийг зохих ур чадвартай боловсон хүчнээр хангах. Компанийн болон туслан гүйцэтгэгчийн хэрэгцээнээс хамаарч сургалтын хөтөлбөр болон ажлын байран дахь сургалтууд, тусгай мэргэжил олгох сургалтууд зэргийг зохион байгуулах.
- Жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу ажилчдын ур чадварыг дээшлүүлэх

шаардлагатай сургалтуудыг зохион байгуулах.

- Бараа материалын тооллого, шаардлага хангагдахын өмнөх судалгааг гүйцэтгэж, орон нутгийн иргэд, засаг захиргаатай хамтран орон нутгаас ханган нийлүүлэлт хийх боломжтой ханган нийлүүлэгчдийг тодорхойлох.
- Орон нутгийн хамтын ажиллагааны менежментийн төлөвлөгөөний хүрээнд орон нутгийн иргэд, захиргааны байгууллагуудтай хамтарч орон нутгийн бизнесүүдэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, ханган нийлүүлэлтийн хөтөлбөрийг боловсруулах боломжийг судлах.

Шинэжинст болон Баян-Өндөр сумдын иргэдийн хувьд хөдөлмөр эрхлэлтийн талаар өндөр хүлээлт үүссэн байна. Барилга угсралтын болон үйл ажиллагааны үе шатанд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үүсэж буй хүлээлтэд хүрэхгүй байх нь орон нутгийн иргэдийн дунд сэтгэл хангалуун бус байдлыг үүсгэж болзошгүй. Хүний нөөцийн менежментийн төлөвлөгөөнд орон нутгийн иргэдийг нээлттэй ажлын байранд ажиллах боломжийг дэмжих зорилготой зохицуулалт, шаардлагыг тусгасан заалтуудыг оруулна. Үүнд:

**Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Төслийн нөлөөллийн бүсэд тодорхой хугацаанд оршин суусан, оршин суух харьяаллыг баталгаажуулах баримт бичигт үндэслэн “орон нутгаас ажилд авах” шаардлагыг боловсруулах.
- Төсөлд чадварлаг боловсон хүчнийг татах зорилгоор (Шинэжинст, Баян-Өндөр сумдын) ур чадвартай иргэдийг татах бодлого баримтлах. Тус бодлогод өмнө нь компанид улирлын чанартай ажиллаж байсан ажилчид болон компанийн тэтгэлэгт хамрагдсан төгсөгчдийг хамрагдуулах.
- Орон нутагт тохирсон, хоёр талын ашиг сонирхолд нийцсэн ажлын байруудыг зарлах.
- Орон нутагт амьдарч буй шаардлага хангасан ажил хайгчдыг дэмжих зорилгоор орон нутгийн сургалтын байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдгээр хүмүүсийн оролцоог дэмжих.
- Нийт ажилд авах хүний тоо, хугацаа, ур чадварын шаардлага болон уурхайн талбайд хүнд машин механизм жолоодох эрх, үнэмлэхийн төрөл болон жолоо барьсан нийт жилийн тоо гэх мэт шаардагдах ур чадварын талаар мэдээллийг олон нийттэй харилцах албаны мэргэжилтнээр дамжуулан орон нутгийн иргэдэд тогтмол хүргүүлэх.

Зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлаас үзэхэд, улсын хэмжээнд шаардлага хангасан чадварлаг боловсон хүчин хангалттай байх төлөвтэй байна. Харин орон нутгийн хэмжээнд чадварлаг боловсон хүчин хязгаарлагдмал байна. ХАТ-д чадварлаг боловсон хүчнийг татах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Дотоодын мэргэжилтнүүдийг ажиллуулах боломжгүй тохиолдолд сургалт болон бусад нийцлийг хангах зорилготой ажлуудад олон улсын мэргэжилтнүүдийг хугацаат гэрээгээр ажиллуулах.
- Орон нутгийн ажилчдын ур чадварыг хөгжүүлж, орон нутгийн ажил горилогчийн ур чадвар, туршлага, шаардлагыг хангуулах санаачилгуудыг багтаасан Орон нутгийн хамтын ажиллагааны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх (дадлага, худалдаа арилжаа болон мэргэших тэтгэлэгт хөтөлбөр, г.м). Тус санаачилгууд болон компанийн өмнө хэрэгжүүлсэн орон нутгийн хөгжлийн санаачилгууд нь орон нутгийн иргэд, захиргаатай харилцах харилцааг бэхжүүлнэ.

- Эмэгтэйчүүдийг удирдлага, техник/инженерийн албан тушаалд ажиллах, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Эмэгтэйчүүдэд ажлын байранд үүсэж болох эрсдэлийг бууруулах зорилгоор ажлын дарамт шахалтгүй орчныг бүрдүүлэх хатуу бодлого баримтлах.
- Төслийн хүрээнд орон нутагт амьдарч буй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор эмэгтэйчүүд эрхлэх боломжтой сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хүнсний ногоо боловсруулах/даршлах зэрэг хөдөлмөр эрхлэлтийг бий болгох боломжуудыг судлах.

Компани нь нутгийн ард иргэд, оролцогч талуудтай удаан хугацаанд үргэлжлэх үнэ цэнийг бий болгоход анхаарч ажиллана. Төслөөс үүсэж болзошгүй эерэг нөлөөлөл нь гол оролцогч талуудтай түншлэл бий болгох, хэрэгжүүлэх орон нутгийн хөгжлийн санаачилгууд болно. Компани нь Баянхонгор аймаг, Шинэжинст, Баян-Өндөр сумдын захиргаатай албан ёсны хамтын ажиллагааны гэрээг 2014 оноос байгуулсан ба (нийт 6 календарийн жил) хамгийн анх 2006 оноос хойш орон нутагтай харилцаа үүсгэж ажилласан байна. ОНХАГ нь төслийг орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй нийцүүлэн, орон нутгийн иргэдийн амьжиргаа, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой юм. ОНХАГ-ний хүрээнд хэрэгжүүлсэн үндсэн үйл ажиллагаа болон хөтөлбөрүүд нь орон нутгийн боловсрол, эрүүл мэндийн байгууламжуудыг сайжруулах, сурагчдыг дээд боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх, малчин өрхүүдийн амьжиргааг сайжруулахад чиглэсэн байна. Компани нь одоогийн хэрэгжүүлж буй орон нутгийн хөгжлийн бодлогоос гадна, ОНХАГ-г хэрэгжүүлэх зааварчилгаа бүхий Орон нутгийн хамтын ажиллагааны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. Үүнд дараах зорилтуудыг тусгана:

**Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Засгийн газар, олон улсын донор байгууллагууд, бусад бүс нутгийн хувийн компаниудтай хамтран ажиллах түншлэлийг бий болгож, санхүүжилт олох боломжуудыг эрэлхийлэх;
- Үүсэж болзошгүй нөлөөлөлд үндэслэн орон нутгийн зорилтод хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд тэдгээрт төслийн нөлөөнд өртөж болзошгүй иргэдийг хамруулах;
- Тогтвортой үр дүнг бий болгоход анхаарч хүний капиталд (хөрөнгийн зарцуулалт, дэд бүтэц бус) хөрөнгө оруулалт хийхэд ач холбогдол өгөх. Компанийн зүгээс хэрэгжүүлэх ажлуудыг хэрэгцээнд суурилсан, бүх талын оролцоог хангасан төлөвлөлт, хэрэгжилтийг нэн тэргүүнд тавих. Энэ нь орон нутагт суурилсан хөгжлийн төлөвлөлтийн тогтвортой байдал болон амжилттай хэрэгжилтэд чухал нөлөө үзүүлнэ.
- ОНХАГ-г эцэслэхээс өмнө нутгийн ард иргэдтэй хэлэлцүүлэг зохион байгуулж, орон нутгийн хөгжлийн боломжуудыг тодорхойлох. Амжилттай хэрэгжүүлж буй орон нутгийн хөгжлийн ажлуудын талаар мэдээлэл авснаар цаашид орон нутгийн хэрэгцээ, тэдгээрийн оролцоог (тэтгэлэгт хөтөлбөр, усны асуудалтай холбоотой хийх ажлууд, г.м) нэмэгдүүлэх боломжтой болох юм.

**Дээр дурдсан менежментийн арга хэмжээнүүдтэй холбоотойгоор дараах хяналт, шинжилгээний шаардлагуудыг санал болгож байна:**

Хөдөлмөр эрхлэлт:

- Эрэгтэй, эмэгтэй хүйсийн бүртгэл мэдээлэл, удирдлагын албан тушаал (супервайзор болон түүнээс дээш албан тушаал) болон сум-аймаг-дотоод-гадаадын боловсон хүчний бусад түвшинд ажиллах харьцаанд дүн шинжилгээ хийх.
- Ажилчдаас мэдүүлсэн, боловсруулсан, шийдвэрлэсэн санал гомдлын тоо.
- Дарамт шахалт эсхүл ажлын байранд үүссэн ялгаварлан гадуурхахыг мэдээлсэн

зөрчлийн тоо.

Орон нутгийн хөгжил, орон нутгийн хамтын ажиллагаа:

- Үйл ажиллагааны өгөгдлүүд (санхүүжилт, хүний нөөц), тэдгээрийн үр ашигтай байдалд хяналт тавих.
- Оролцоонд хяналт тавих (цар хүрээ, үр дүнтэй байдал).
- Үр дүн (орон нутгийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болох үр дүн), төлөвлөсөн үр дүнд хүрч байгаа эсэхэд хяналт тавих.
- Нөлөөллийг дүгнэх (орон нутгийн хөгжлийн төсөл, хөтөлбөрийн үр дүн).

Олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа:

- Компани нь хаагдсан эсвэл дахин хэлэлцэх санал гомдол зэрэг санал гомдлуудын бүртгэлийг шалгана.
- Төслийн ажилтнууд нь бэлтгэн боловсруулсан, олон нийтэд хүргүүлсэн мэдээллийн материалыг тухайн байршлаар нь бүртгэж хадгална.
- Төслийн ажилтнууд нь орон нутгийн иргэдтэй хийсэн ажлуудыг Оролцогч талуудын хамтын ажиллагааны бүртгэлд бүртгэнэ.

## 4.10 Газар ашиглалт

### 4.10.1 Одоогийн нөхцөл байдал

ХАТ-ийн нөлөөллийн бүсэд байрлах сумдын газар нутагт отрын мал аж ахуй нийт газар ашиглалтын дийлэнх хувийг эзэлдэг ба мал сүрэгт хонь, ямаа, тэмээ зонхилж байна. Зарим тохиолдолд мал хол зайд улирлын чанартай нүүдэллэх нь тэдгээрийг амьд үлдэхэд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд уламжлалт бэлчээрийн менежментийн арга юм. Нийгмийн суурь үнэлгээ судалгааны ажлын хүрээнд хийгдсэн өрхийн судалгаанд оролцсон өрхүүдийн хувьд жилдээ 5 удаа нүүдэллэдэг гэж тэмдэглэсэн байна. Бэлчээр ашиглалт нь тухайн жил, улирлаас шууд хамааралтай байдаг. Зуншлагын бэлчээр ашиглалтыг албан бус байдлаар зохицуулдаг бөгөөд тухайн жилийн цаг агаар, ургамлын нөхцөл байдал, малын тоо толгой, тухайн малчин өрхийн гишүүдийн тоо зэргээс хамаарч заасан зуншлагын бэлчээр газрууд гэж байдаггүй байна. Газрын тухай хуульд отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана гэж заасан байдаг. Харин малчид өвөлжөө/хаваржааг (0.07 га газар) эзэмшлийн гэрчилгээтэйгээр ашиглаж болдог байна.

Малчин өрхүүд бэлчээрийн нөхцөл байдлаас хамаарч бусад улиралд байнгын нүүдэллэдэг боловч бэлчээрийн хүртээмжтэй байдлаас хамааран өөрийн өвөлжөөний газарт эргэн ирдэг. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд ямар нэгэн өвөлжөөний газар бүртгэгдээгүй байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайгаас 10 км-ын радиуст нийт 7 өвөлжөөний газар бүртгэгдсэнээс 3 нь Баян Хөндийн ойролцоо, 4 нь Цэнхэр Номингийн ойролцоо байрлаж байна. Долоон өвөлжөөний газрын зургаа нь Уртын гол багт (Шинэжинст сум), үлдсэн нэг нь Идрэн багт харьяалагдаж байна. Сайтад нэвтрэх замаас 2.5 км зайд нийт 29 өвөлжөөний газар бүртгэгдсэн байна (хамгийн ойрхон өвөлжөөний газар нь 0.01 км зайд байрладаг). Тухайн өвөлжөөний газруудтай холбоотой байнгын байршилтай барилга байгууламж байхгүй байна.

### 4.10.2 Нөлөөлөл болон менежмент

ХАТ-ийн барилга угсралт, уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор газар худалдан авах, газар хуваарилах шаардлага үүснэ. Төсөл нь 150 га газрыг хамрах бөгөөд 90 гаруй га газрыг хүрээлэн уурхайн хашаа байгуулна. Барилга угсралтын болон ашиглалтын үе

шатанд ашиглах зориулалттай газраас бусад газарт түр байгууламж байгуулагдахгүй. Барилга угсралтын үйл ажиллагаанд бараа материал ашиглах тул газар хөндөлт хязгаарлагдмал байдлаар (0.1 га-аас бага газар) хийгдэнэ. ХАТ-ийн талбай болон Шинэжинст сумын (Уртын гол багт) төвийн хооронд байрлах авто замд барилгын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хэсэгчилсэн засвар хийгдэнэ. Төсөл хэрэгжилтийн болон барилга угсралтын үеэр замын ачааллын хувьд өдөрт дунджаар 7.5 тээврийн хэрэгсэл (одоогийн байгаагаас 13%-иар нэмэгдэх) дайран өнгөрөх төлөвтэй байна. Уурхайн үйл ажиллагааны үе шатанд замын ачааллын хувьд өдөрт дунджаар 4 тээврийн хэрэгсэл дайран өнгөрөх төлөвтэй байна (одоогийн байгаагаас 1%-иар нэмэгдэх).

Газар ашиглалтын нөлөөллийн эх үүсвэрүүд нь Шинэжинст сумын Уртын гол багт үүсэх төлөвтэй байна. Уртын гол багт Баян Хөндийн орд газар байрлах бөгөөд тус байршилд ХАТ-ийн үндсэн дэд бүтцийн байгууламжууд болох боловсруулах үйлдвэр, ажилчдын байр сууц, сайтад нэвтрэх зам байрлана. ХАТ-ийн тусгай зөвшөөрлийн талбайгаас (Баян Хөндий, Алтан Нар) 10 км радиус бүхий газар мөн уурхайн сайтад нэвтрэх замаас 5 км радиус бүхий газрыг (замын хоёр тал бүрээс 2.5 км газар байх) нөлөөллийн бүс гэж тодорхойлсон ба үүнийг төслийн болзошгүй нөлөөлөл болон орон нутгийн малчдын газар ашиглалтад үндэслэн тогтоосон байна (Зураг 5).

ХАТ-тэй холбоотойгоор биет нүүлгэн шилжүүлэлт хийгдэхгүй бөгөөд төслөөс дараах нөлөөллүүд үүсэж болзошгүй байна.

- Дуу чимээ, тоосжилт, чичиргээ зэрэг нь бэлчээрийн газарт нөлөөлөл үүсгэж болзошгүй;
- Бэлчээрийн газар алдагдах/нэвтрэх боломж хязгаарлагдсанаар орон нутгийн хэмжээнд бэлчээр ашиглах өрсөлдөөн болон маргаан үүсэх зэрэг нөлөөллүүд үүсэж болзошгүй;
- Улирлын чанартай бэлчээрийн газарт нэвтрэх боломжгүй болох, бэлчээрийн талбай алдагдах нь бага хэмжээний эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт үүсгэж болзошгүй.

Доор дурдсан санал болгож буй нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой нөлөөллийн хэмжээ “Бага” байх төлөвтэй байна.


**Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Орон нутгийн мал аж ахуйн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах боломжийг бүрдүүлэн төслийн барилга угсралтын болон үйл ажиллагааны үе шатуудыг зохион байгуулж, удирдах.
- Газар ашиглалт, амьжиргааг дэмжих менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.
- Орон нутгийн хамтын ажиллагааны менежментийн төлөвлөгөөгөөр газар ашиглалтад үүсэж болзошгүй нөлөөллийг удирдах Малчдын амьжиргааг дэмжих хөтөлбөрийг (МАДХ) боловсруулах. МАДХ нь Уртын гол багийн төслийн талбайг бэлчээрт ашиглаж байсан малчдад чиглэх бөгөөд үүний дараа заасан шаардлага хангаж буй эсэхээс хамаарч Уртын гол багийн иргэдийг хамруулна. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээгээр шаардлага хангасан малчдад дэмжлэг үзүүлнэ. Идрэн багт хэрэгжүүлэх МАДХ-ийн хамрах хүрээг Алтан Нар орд газрыг бүтээн байгуулалтын явцад тодорхойлох.
- МАДХ-ийн зохион байгуулалтад малчид, баг болон сумын засаг захиргаа, бусад








мэргэжилтнүүдтэй хийх хэлэлцүүлгийг багтаах.

**Хяналт шинжилгээний шаардлагуудад дараах багтана:**

- МАДХ-т тодорхойлсон арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;
- Газар ашиглалт, амьжиргаатай холбоотой санал гомдолд хяналт тавих;
- Газар ашиглалтаас үүсэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ, орон нутгийн хамтын ажиллагааны хэрэгжилттэй холбоотой олон нийтийн сэтгэл ханамжид мониторинг хийх.



**LEGEND**

- |   |  |
|---|--|
| • Soum Center   |  Khundii Project Mineral Licensed Area                          |
| ▲ Winter Camps  |  Water Borefield Area   |
| — Site Access Road  |  Area Within 2.5 km from the Access Road                        |
|  Soum Border |  Area Within 10 km from the Altan Nar Mineral Licensed Area     |
|  Bagh Border |  Area within 10 km from the Bayan Khundii Mineral Licensed Area |

Зураг 5 Малчдын бүртгэлтэй өвөлжөөний газрууд

## 4.11 Соёлын өв

### 4.11.1 Одоогийн нөхцөл байдал

Шинэжинст, Баян-Өндөр сумдад дунд хадны зургууд, палеонтологийн нөөц бүхий газар зэрэг олон тооны археологийн олдвор бүхий газрууд байдаг. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хийгдсэн судалгааны үеэр уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд ямар нэгэн археологийн болон палеонтологийн соёлын өв бүхий нөөц газар илрээгүй байна. Мөн тус судалгаагаар цаашид соёлын өв илрүүлэх магадлал маш бага гэж онцолсон. Шинэжинст, Баян-Өндөр сумдад олон тооны уламжлалт, ариун дагшин газар байдаг ба тэдгээрт уул/толгод, булаг шанд/усны эх үүсвэрүүд, овоо зэрэг амьд өв гэж нэрлэгддэг соёлын биет өв багтаж байна. Эдгээр газрууд нь ХАТ-ийн уурхайн тусгай зөвшөөрлийн талбай эсхүл нөлөөлөл үүсэх талбайн ойролцоо газруудад байрладаггүй байна. Амарбуянт хийд нь Шинэжинст сумаас баруун зүгт 50 км-ийн зайд оршдог бөгөөд орон нутгийн соёлын биет амьд өв юм. Хэлэлцүүлгээр хамгийн алдартай, нийтлэг төрлийн соёлын биет бус өвийг тодорхойлоход дараах зүйлсийг илрүүлсэн байна. Үүнд:

- Уламжлалт уртын дуу (Уртын дуу);
- Сумын шашны ёслол үйлддэг Амарбуянт Буддын сүм хийдийн мөргөлийн ёслол;
- “Тохил” (хавтан дээр суурилсан тоглоом) тоглоом;
- “Чулуун царгил” уламжлалт хөгжмийн зэмсэг;
- Бэлэг тэмдэг, түүхэн өв залгамж болсон “Залаа Жинст ямааны ноолуур” үүлдэр;
- Монгол малчид, тэдгээрийн аж амьдралтай холбоотой өвөрмөц уламжлалууд.

### 4.11.2 Нөлөөлөл болон менежмент

ХАТ-ийн үйл ажиллагааны явцад илрүүлж болзошгүй бүртгэгдээгүй палеонтологи, археологийн эд зүйлсэд биет алдагдал, гэмтэл учирч болзошгүй. Мөн хоёр сумдад соёлын өвийн газруудыг санаатайгаар хөндөх нөхцөл байдал үүсэж болзошгүй байна. ХАТ-ийн ашиглалтын болон барилга угсралтын үе шатанд ажиллах орон нутгийн бус ажилчид Шинэжинст, Баян-Өндөр сумдын оршин суугчидтай харилцаа үүсгэснээр нутгийн уламжлалт арга ухаан, зан заншил, практикт нөлөөлж болзошгүй юм.

#### **Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Орон нутгийн хамтын ажиллагааны менежментийн төлөвлөгөө, оролцогч талуудын болон харилцаа холбооны менежментийн төлөвлөгөө, газар хөндөлт ба нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө зэргийг боловсруулж хэрэгжүүлэх.
- Тохiolдлын олдворын журмаар илрүүлсэн түүх, соёлын ач холбогдол бүхий соёлын өвийн аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдал болон тэдгээрийн зохицуулалтыг ханган ажиллах.
- Холбогдох захиргаа болон эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, ХАТ-ийн талбайн ойролцоо хууль бусаар гүйцэтгэж буй газрын гүний судалгаа, малтлага, хайгуулын ажил зэрэг үйл ажиллагааг тайлагнаж ажиллах.
- Шашны зан үйл, уламжлалт арга ухаан, ардын зохиол, соёлын орон зай зэрэг соёлын биет бус өв болон амьд өвтэй холбоотой тулгамдаж буй асуудал, нөлөөллийн талаар орон нутгийн иргэдтэй тогтмол хэлэлцүүлэг зохион байгуулах.
- Соёлын өвийн тухай заалт, соёлын төрөлжүүлэлтийг харилцан хүндэтгэх зарчимд суурилсан зөвшөөрөгдсөн зан үйлийг агуулсан ёс зүйн дүрэм болон шинээр ажилд



ороход зайлшгүй суух шаардлагатай сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

- Орон нутгийн хамтын ажиллагааны төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилтээр орон нутгийн соёлын арга хэмжээг дэмжих, орон нутгийн уламжлалт соёлыг хадгалж хамгаалахад сумын захиргаа болон орон нутгийн ард иргэдийн хамтын ажиллагааг үргэлжлүүлэх.

#### 4.12 Хөдөлмөрийн болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал

##### 4.12.1 Одоогийн нөхцөл байдал

Төсөл хэрэгжих газарт эрүүл мэндийн үйлчилгээ, цар хүрээ хязгаарлагдмал байна. Хоёр сумдын эмнэлгүүдэд эрүүл мэндийн ерөнхий үйлчилгээ үзүүлдэг байна. Шинэжинст сумын эмнэлэг 10 ортой, Баян-Өндөр сумын эмнэлэг 9 ортой. Шинэжинст суманд 2 эмч ажилладаг бол Баян-Өндөр суманд нэг эмч ажилладаг байна. Сумын эмнэлгүүд нь шаардлагатай тохиолдолд түргэн тусламж, эх барих эмчилгээг үзүүлж ажилладаг. Зүрх судасны өвчин, цус харвалт, хавдар, элэгний хатуурал зэрэгтэй холбоотой нас баралт сум, аймгийн түвшинд ижил төстэй байна. 2018 оны байдлаар Баянхонгор аймагт халдварт өвчний тоо бага байсан боловч нийт халдварт өвчний 70%-ийг БЗХӨ эзэлсэн байна. Шинэжинст болон Баян-Өндөр сумдын хувьд гэмт хэргийн тохиолдол маш бага бүртгэгдсэн байна. Гэмт хэргийн дийлэнх тохиолдол нь архи согтууруулах ундаатай холбоотой байсан бөгөөд тэдгээр нь олон нийтийн тайван байдлыг алдагдуулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх шалтгаан болж байна.

##### 4.12.2 Нөлөөлөл болон менежмент

Хөдөлмөр, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой гол нөлөөллүүдэд сайтын алслагдсан байдал, онцгой байдлын үед ажилчдыг зохицуулах хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны нөлөөллүүд багтаж байна. Шинэ дэд бүтэц, боловсон хүчнийг бүрдүүлсэн уурхайн бүтээн байгуулалтын явцад ажлын байранд осол гэмтэл гарч болзошгүй. Ажилчид болон орон нутгийн оршин суугчдын хооронд харилцаа холбоо тогтоох нь халдварт өвчнийг нэмэгдүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн байгууламжуудад ачаалал үүсгэж болзошгүй. Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор архидалт, биеэ үнэлэх/гэмт хэргийн тохиолдлууд бий болсноор нийгмийн дунд хагарал үүсгэх мөн эрүүл ахуйд нөлөөлж болзошгүй байна. Орон нутгийн иргэд/ТББ-ууд төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэл хангалтгүй гэж үзсэн тохиолдолд төслийн үйл ажиллагааг тасалдуулж болохыг харгалзан авч үзнэ.

Доор дурдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд үүсэх нөлөөлөл “Бага” байна. Төслийн үйл ажиллагааг орон нутгийн иргэд тасалдуулах нь төслөөс үр ашгийг хүртэх хугацааг хойшлуулах мөн олон нийтийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд нөлөө үзүүлэх тул үүсэх нөлөөлөл “Дунд” байна. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлснээр нөлөөллийн түвшин “Бага” байх бөгөөд онцгой байдлын үед үүсэх нөлөөллийн түвшин “Дунд” байх төлөвтэй байна.

#### **Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө, Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө, Онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөө зэргийг боловсруулж хэрэгжүүлэх.

- Компани нь төслийн ажилчдад зориулсан эрүүл мэндийн байгууламжийг уурхайн талбайд ажиллуулна. Онцгой байдлын үед уурхайн талбайд түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх боломжтой болох.
- Онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээнд нутгийн ард иргэдэд нөлөөлөл үүсгэх уурхайн талбайгаас гадна үүссэн зөрчлийг зохицуулах бөгөөд цаг тухайд мэдэгдэл хүргүүлэх, харилцаа холбоо болон нүүлгэн шилжүүлэлтийг зохицуулах зэрэг ажлуудаар орон нутгийн иргэд, засаг захиргаатай хамтарч, онцгой байдлын үеийн бэлэн байдлын чадавхыг бэхжүүлж ажиллах.
- ХАТ нь Олон улсын Цианитын Менежментийн Дүрэмд заасан зарчмуудыг үйлдвэрлэл, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд баримталж, цианитыг олон улсын аж үйлдвэрийн салбарын сайн практикийн дагуу ашиглах.
- Уурхайн талбайд олон нийт болон мал амьтан нэвтрэхээс хамгаалах хашаа хаалт хийх бөгөөд үхэлд хүргэх ба үхэлд үл хүргэх зэвсэгтэй хамгаалалтын ажилтнууд нь уурхайн талбайд олон нийтийг зөвшөөрөлгүй нэвтрэхээс урьдчилан сэргийлж ажиллах. Орох болон гарах бүх цэгүүдэд замын тэмдэглэгээ хийх ба хашаалсан газруудад тэмдэглэгээ хийсэн байна. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор талбайн дотор болон гаднах хэсэгт мөрдөх арга хэмжээнүүдийн талаар тогтмол мэдээлнэ. Тус арга хэмжээнүүд нь оролцогч талуудад уурхайн талбай болон гадна хэсэгт аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлуудыг мэдээлэх ба олон нийтэд хүрэх хөтөлбөрийн хүрээнд зочдын аюулгүй байдлыг хангаж, хяналттай орчинд уурхайн талбайд нэвтрүүлэх.
- Уурхайн талбайд бичил уурхайн олборлогчдыг нэвтэрч үйл ажиллагаа эрхлэхээс урьдчилан сэргийлнэ. Энэ ажиллагааг орон нутгийн ард иргэд, хууль сахиулах байгууллагуудтай зорилтод харилцаа холбоо үүсгэж, хамтран ажиллаж гүйцэтгэх бөгөөд хариуцсан ажилтнуудад аюулгүй байдал ба хүний эрхийн талаар сайн дурын зарчмуудыг баримталж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, зохих сургалтад хамрагдуулах.
- Ажилчид болон туслан гүйцэтгэгчдийг эрүүл мэндийн үзлэгт хамрагдуулах бөгөөд эрүүл мэндийн талаар сургалтад хамрагдуулсан байна. Боловсон хүчнийг уурхайн сайтад байрлуулж, орон нутгийн иргэдтэй харилцаа үүсгэх явдлыг үйл ажиллагааны үеэр аль болох бага байлгахад зорьж ажиллах ба бүх ажилчид, туслан гүйцэтгэгчдэд чандлан мөрдөх уурхайн кемпийн дүрмийг мөрдүүлэх.
- ХАТ нь Орон нутгийн хамтын ажиллагааны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан халдварт өвчнийг бууруулах, барилга угсралтын болон үйл ажиллагааны үе шатанд ус, ариутгал, хог хаягдлын менежмент зэрэг хүрээлэн буй орчны эрүүл мэндэд үзүүлэх аюулаас урьдчилан сэргийлэх зорилготой Орон нутгийн нийтийн эрүүл мэндийн ажлуудад дэмжлэг үзүүлэх боломжийг эрэлхийлж ажиллах.
- Төсөл нь шаардлагатай тохиолдолд, орон нутгийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй харилцаа холбоо тогтоох замаар орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээнд үзүүлэх болзошгүй дарамтыг бууруулж ажиллах бөгөөд Олон нийтийн эрүүл мэндийн үйлчилгээнд стратегийн дэмжлэг үзүүлэх арга замуудыг олж тодорхойлох.
- Оролцогч талуудын болон харилцаа холбооны менежментийн төлөвлөгөөнд нөлөөллийг удирдах арга хэмжээний талаар оролцогч талуудтай хамтран ажиллах ерөнхий заалтуудыг оруулах бөгөөд санал гомдлын журмаар олон нийттэй холбоотой санал гомдлыг зохицуулж ажиллах.

#### **Хяналт шинжилгээний шаардлагуудад дараах багтана:**

- Халдварт болон халдварт бус өвчин, осол гэмтлийн тохиолдолд хяналт тавих;
- Нутгийн иргэдээс олон нийтийн эрүүл мэндийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой ирүүлсэн санал гомдлын бүртгэлд хяналт тавих;
- Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой үүссэн зөрчилд хяналт тавих;

- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын үзүүлэлтүүдэд хяналт тавих;
- Ажилд орохоос өмнөх эмнэлгийн үзлэг болон ажилчдыг эрүүл мэндийн тогтмол үзлэгт хамруулах.

## 4.13 Зам тээвэр

### 4.13.1 Одоогийн нөхцөл байдал

Төслийн талбай нь аюулгүй ажиллагаа, замын хөдөлгөөний зохицуулалт багатай газар бөгөөд тус газарт мотоциклын хэрэглээ зонхилдог. Аймгийн хэмжээнд одоо байгаа замын стандарт муу байгаа нь гол асуудал болж байна. Байгалийн элэгдэл, газрын гадаргуун гэмтэл зэрэг нь нийтлэг тохиолдох ба хөрсний чанарын хувьд бүтэц муутай байдаг. Одоогийн байдлаар авто тээврийн замын хөдөлгөөний тоо бага байгаа ба төсөл хэрэгжиж эхэлснээр бүсийн/дүүргийн зам тээврийн сүлжээнд тодорхой хэмжээний авто тээврийн хөдөлгөөн нэмэгдэнэ. Орон нутгийн зам тээврийн сүлжээний талаар бүрэн ойлголттой болох зорилгоор компаниас зам тээврийн суурь мэдээллийг цуглуулах ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд үүнд Баянхонгор аймгийн төвөөс Шинэжинст сум хүртэлх замыг хамарсан байна. Суурь судалгаагаар замын хөдөлгөөнтэй холбоотой олон төрлийн мэдээлэл цуглуулсан байна. Өдөрт бүртгэгдсэн хамгийн бага хэмжээ нь 29 тээврийн хэрэгсэл байсан бол хамгийн их нь 103 тээврийн хэрэгсэл байсан байна. Тээврийн хэрэгсэл хамгийн их бүртгэгдсэн өдрүүд нь зуны баяр наадмын өдрүүдтэй давхцаж байсан. Төслийн болзошгүй нөлөөллийг үнэлэхэд өдөрт дунджаар 55 тээврийн хэрэгсэл дайран өнгөрнө гэж тооцоолсон байна.

### 4.13.2 Нөлөөлөл болон менежмент

Барилга угсралтын ажил үргэлжлэх 12 сарын хугацаанд Улаанбаатар хотоос ХАТ чиглэлийн замын хөдөлгөөн нь замын хөдөлгөөний бүртгэгдсэн суурь мэдээллээс 13%-иар нэмэгдэх (жишээ нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөн өдөрт дунджаар 7.5 ба түүнээс их хувиар) төлөвтэй байгаа ба нөлөөллийн хэмжээ “Бага” байна. Үйл ажиллагааны үе шатанд зам тээврийн хэрэглэгчид, замын хэрэглээ маш бага байх тул замын хөдөлгөөний нөлөөлөл “Маш бага” байна. Уурхайн ашиглалтын үйл ажиллагааны үе шатанд замын хөдөлгөөн 1%-иар нэмэгдэх төлөвтэй байна. ХАТ-өөс Шивээ Хүрэнгийн хилийн боомт хүртэлх замын хувьд барилга угсралтын ажил үргэлжлэх хугацаанд өдөрт дунджаар 2 тээврийн хэрэгсэл дайран өнгөрөх тул нөлөөллийн хэмжээ “Маш бага” байна. Барилга угсралтын болон ашиглалтын үе шатанд зам тээврийн хөдөлгөөн бага байх тул зэрлэг ан амьтан, мал, тоосжилт, дуу чимээтэй холбоотой нөлөөллүүд болон зам тээврийн сүлжээнд эвдрэл учруулах зэрэг нөлөөллийн хэмжээ “Бага” байх төлөвтэй байна.

#### **Менежментийн болон нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээнүүдийг санал болгосон байна:**

- Замын хөдөлгөөн ба зам тээврийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.
- ХАТ болон холбогдох замын хөдөлгөөнөөс үүсэх нөлөөлөлд өртсөн малчид болон нутгийн иргэдтэй замын хөдөлгөөний талаар хэлэлцүүлэг зохион байгуулах. Цагдаа, хил гааль болон онцгой байдлын газруудтай хэлэлцүүлэг зохион байгуулж, онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ, бэлэн байдлыг хангах шаардлагатай.
- Орон нутгийн хот суурин газруудын төвөөр дамжих, тойрон зорчиход тээврийн хэрэгслийн хурданд хязгаарлалт тавих. Жолооч нарын хувьд эрсдэлийг үнэлсэн, урьдчилан тодорхойлсон замаар зорчих.

- Шаардлагатай тохиолдолд замын хэсэгчилсэн засварын ажлууд болон засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх.
- Уурхайн болон үйлчилгээний бүх ажилчид аюулгүй байдлыг хангаж замын хөдөлгөөнд зөвхөн өдрийн цагаар оролцох шаардлага тавих.
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний бүтээмжтэй байдлыг хангах зорилгоор тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах, боломжтой тохиолдолд тээврийн хэрэгслийн тоог бууруулах.
- Хурдны хязгаарлалт, замын хөдөлгөөний дүрэм, урьдчилан заасан замын чиглэлийн дагуу зорчихыг хатуу чанд мөрдүүлэх.
- Шаардлага хангасан тоо хэмжээ бүхий замын тэмдэглэгээг суурилуулах.  
Хүнд даацын эсхүл ачаа хэтрүүлсэн хүнд даацын тээврийн хэрэгсэлд дагалдан явах тээврийн хэрэгслийг ашиглах.

**Хяналт шинжилгээний шаардлагуудад дараах багтана:**

- Замын хөдөлгөөний хяналтын үнэлгээг амжилттай гүйцэтгэх, замын хөдөлгөөний ослын тоог хянах.
- Агаарын чанар, дуу чимээний зорилтод үзүүлэлтүүдийг хангах зорилготой тээврийн хэрэгсэлтэй холбоотой агаарын чанар, дуу чимээний мониторинг хийх.
- Барилга угсралт, ашиглалтын үе шатны замын хөдөлгөөний нөлөөллийг үнэлэх, замын нөхцөл байдлын мониторинг хийх.
- Нөхөн сэргээлтийн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд доройтсон газарт нөхөн сэргээлтийг амжилттай гүйцэтгэх.

#### 4.14 Хуримтлагдах нөлөөллүүд

Энэхүү БОННУ-ний хамрах хүрээг тодорхойлох үе шатанд ан амьтны амьдрах орчин тарж сарних, гүний усны нөөцийн эрэлт нэмэгдэх зэрэг байгаль орчны болзошгүй хуримтлагдах нөлөөллүүдийг ХАТ болон ирээдүйд хэрэгжүүлэх уул уурхайн бүтээн байгуулалтын ажлуудын болзошгүй үр дүн болно хэмээн харгалзан авч үзсэн. Мөн орон нутгийн хүн амын шилжилт хөдөлгөөн бий болох, зам тээврийн эрсдэлүүд нэмэгдэх, олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой нөлөөлөл бий болох зэрэг нийгэмд үзүүлж болзошгүй хуримтлагдах нөлөөллүүдийг ХАТ болон ирээдүйд хэрэгжүүлэх уул уурхайн бүтээн байгуулалтын ажлуудын болзошгүй үр дүн болно хэмээн харгалзан авч үзсэн. Гэсэн хэдий ч, одоогийн байдлаар тухайн бүс нутагт богино болон дунд хугацаанд нөөцийн хөгжүүлэлтийн төслүүд хэрэгжих мэдээлэл байхгүй байна.

Төслийн алслагдсан байдал, уурхайн ашиглалтын богино хугацаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, бүс нутагт богино болон дунд хугацаанд нөөцийн хөгжүүлэлтийн төслийн хэрэгжих магадлал бага байгаагаас аливаа хуримтлагдах нөлөөллийн төрлийн хэмжээ “Бага” байх төлөвтэй байна.

## 5. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТ

### 5.1 Төслийн БОНМ

Компани нь төсөлтэй холбоотой бүхий л байгаль орчин, нийгмийн (БОН) тулгамдсан асуудлуудыг удирдах Байгаль орчин, нийгмийн менежментийн системтэй (БОНМС) байна. БОНМС нь компанийн БОН-ийн зорилтуудад хүрэх, ЕСБХБ-ны шаардлагуудад бүрэн нийцэх зорилгоор төслийн бүх үе шатанд хэрэгжүүлэх БОН-ийн удирдлагын процессыг бий болгодог.

### 5.2 Төслийн менежментийн төлөвлөгөөнүүд

Төслийн БОН-ийн удирдлагыг бодлого, менежментийн төлөвлөгөө, дэд түвшний журмууд, маягтуудаар хэрэгжүүлнэ. Дараах хүснэгтэд төслийн үргэлжлэх хугацаанд хэрэгжүүлэх бодлого, менежментийн төлөвлөгөө, стратегиудыг, хүлээгдэж буй гүйцэтгэлийг харуулав.

#### Хүснэгт 2 Хөндий Алтны төслийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнүүд

Менежментийн төлөвлөгөөний нэр	
D0	Удирдлагын хүрээний төлөвлөгөө
D1	Агаарын чанарын менежментийн төлөвлөгөө
D2	Дуу чимээ, чичиргээний менежментийн төлөвлөгөө
D3	Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө
D4	Биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөө
D5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
D6	Аюултай материалын менежментийн төлөвлөгөө
D7	Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө
D8	Туслан гүйцэтгэгч ба худалдан авалтын менежментийн төлөвлөгөө
D9	Онцгой байдлын үед авах арга хэмжээний менежментийн төлөвлөгөө
D10	Хүний нөөцийн менежментийн төлөвлөгөө
D11	Газар ашиглалт, амьжиргааны менежментийн төлөвлөгөө
D12	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө
D13	Оролцогч талуудын болон харилцаа холбооны менежментийн төлөвлөгөө
D14	Орон нутгийн хамтын ажиллагааны менежментийн төлөвлөгөө
D15	Зам тээврийн менежментийн төлөвлөгөө
D16	Газрын хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө
D17	Хаалтын менежментийн төлөвлөгөө

БОННУ-ний бүрэлдэхүүн хэсэг болох менежментийн төлөвлөгөөг компанийн баримталж буй бодлого, журмуудад үндэслэн боловсруулсан болно. Менежментийн төлөвлөгөөнүүдийг барилга угсралтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө боловсронгуй болгож хөгжүүлнэ. Үүнээс гадна, туслан гүйцэтгэгчид нь төсөл дэх өөрсдийн оролцооноос хамаарч ХАТ-ийн ЭМААБОН-ийн Менежментийн системд нийцэх өөрийн баримт бичгийг боловсруулна.

Компани нь ЭМААБОН-ийн Менежментийн систем, БОНМТ-ний хүрээнд дэмжлэг үзүүлэх журам болон менежментийн төлөвлөгөөг боловсруулна. Эдгээр хэрэгжүүлэх баримт бичгүүд төслийн мэргэжилтнүүдийг бүх үе шатанд удирдлагын хяналт болон бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлуудад нэмэлт мэдээллээр хангах юм.

### 5.3 Хяналт шинжилгээ

БОНМС-ийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тогтмол хяналт шинжилгээ болон дүгнэлтийг хийж гүйцэтгэнэ. Хяналт шинжилгээ болон мониторинг нь хамгийн багадаа дараах зүйлсийг хамаарна.

- БОНМС-ийн үндсэн элементүүд байгаа эсэхийг шалгах;
- Компани болон туслан гүйцэтгэгчид төлөвлөгөө болон дэд төлөвлөгөөний баримт бичгүүдийг хэрэгжүүлж байгаа эсэхийг шалгах;
- Хууль тогтоомж, дүрэм журам, ЕСБХБ-ны ГШ болон бусад төслийн стандартуудад нийцэн ажиллаж байгаа эсэхийг хангах;
- Төслийн явцыг БОННУ-д тодорхойлсон ерөнхий зорилтуудтай уялдаж байгаа эсэхийг шалгах;
- Хүлээн авсан санал гомдлыг шийдвэрлэх хариу арга хэмжээний үр дүнтэй байдалд хяналт тавих.

Төслийн гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг (ГГҮ) тодорхойлж, БОНМС болон менежментийн төлөвлөгөөнүүдийн үр дүнтэй хэрэгжилтийг баталгаажуулна.

Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн хяналт шинжилгээг гүйцэтгэх явцад төслийн стандарт, холбогдох хууль тогтоомж, холбогдох стандартуудаар тогтоосон хязгаарлалтуудыг давсныг илрүүлсэн тохиолдолд тухайн зөрчлийг бүртгэж, тайлагнана. Үүнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний хүрээнд тухайн зөрчлийг яаралтай шалгаж, шаардлагатай залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тухайн зөрчлийг бүрэн залруулсныг баталгаажуулж, цааш тайлагнана.

## 6. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, САНАЛ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

### 6.1 Оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагаа

#### 6.1.1 БОННУ-ийн бүрэлдэхүүн хэсэг болох оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагаа

БОННУ-ийн хүрээнд оролцогч талуудын хэлэлцүүлгийг 2019 оны 8 дугаар сард Састайнабилити болон Эко Трейд компаниудын төлөөллөөс бүрдсэн зөвлөх баг гүйцэтгэсэн. Хэлэлцүүлгийг ХАТ-ийн ойролцоо оршин суудаг иргэдийг хамруулан зохион байгуулсан байна. Тус ажилд нарийн төлөвлөлт, хамтын ажиллагаа шаардагдсан бөгөөд компанийн 2006 оны хайгуулын ажлыг эхлүүлснээс хойш хуримтлуулсан хамтын ажиллагааны мэдээлэл болон 2016 онд Эко Трейд ХХК-ын гүйцэтгэсэн БОННУ-г ашигласан байна. Хамтын ажиллагааны зорилго нь Шинэжинст болон Баян-Өндөр сумд, Уртын гол болон Идрэн багууд, Баянхонгор аймгийн нийгмийн нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй ойлголтыг авах юм.

Шинэжинст болон Баян-Өндөр сумдад статистикийн төлөөлөл болгон 78 өрхийг судалгаанд хамрагдуулсан байна. Нийт 28 гол мэдээлэгчийн ярилцлагыг (Шинэжинст, Баян-Өндөр сумдад тус бүр 12, Баянхонгор хотод 4) төлөвлөсөн ба үүнээс 28 ярилцлагыг хийсэн (Шинэжинст суманд 13, Баян-Өндөр суманд 11, Баянхонгор хотод 4) байна. Зорилтод бүлгийн хэлэлцүүлгийг (ЗБХ) сум бүрд 8-10 хүний оролцоотойгоор зохион байгуулж, хүн ам, соёлын өвийн тулгамдсан асуудлууд, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, орон нутгийн засаглал, төсвийн орлого, байгалийн баялаг, бизнес, орлогын эх үүсвэр, боловсрол зэрэг сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлсэн байна. Тус хэлэлцүүлгээр орон нутгийн ард иргэдийн санаа зовниж буй асуудлууд, төслийн талаарх ойлголт зэрэгт ач холбогдол өгч ажилласан. ЗБХ-д орон нутгийг бүрэн төлөөлүүлэх зорилгоор эмэгтэйчүүд, өндөр настай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөөллийг хамрагдуулахыг зорьж ажилласан. Малчидтай хийсэн ЗБХ-үүдэд эмэгтэйчүүдийн ирц эрэгтэйчүүдтэй харьцуулахад их байсан байна. Судалгааны ажлын хүрээнд нийт зургаан ЗБХ-г (ЖДБ-үүд болон ард иргэд) зохион байгуулсан бөгөөд сум тус бүрд гурван хэлэлцүүлэг хийсэн байна.

#### 6.1.2 Компанийн зохион байгуулсан өмнөх хэлэлцүүлэг

Компанийн хувьд нутгийн засаг захиргаа, ард иргэд, байгууллагуудтай хамтран ажилласан 15 жилийн түүхэн туршлагатай. Компани нь 2004 оноос хойш Монгол улсад хайгуулын төслийн ажлуудад 50 гаруй сая ам.долларыг зарцуулсан бөгөөд хэд хэдэн орд газруудыг илрүүлсэн байна. Төслийн байгаль орчины нөлөөллийн ерөнхий үнэлгээ (БОНЕУ) болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний (БОНБНУ) бичиг баримтуудыг Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлгээр танилцуулна. Түүнчлэн, 2017 оноос хойш компанийн хайгуулын ажил, орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Бритиш Колумбын Их Сургуулиас орон нутгийн ард иргэдийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж ажилласан байна.

#### 6.1.3 Монгол улсын Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ (БОНЕУ), БОНБНУ-ийн хууль тогтоомжууд

Эко Трейд ХХК нь 2016, 2017, 2019 онуудад БОНЕУ, БОНБНУ-ийн олон нийтийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж ажилласан. Тус хэлэлцүүлгүүдээр төслөөс үүсэж

болзошгүй нөлөөллүүд, хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөөний талаар сум, багийн ард иргэдэд мэдээлэл өгөх, нутгийн иргэдэд төслийн менежментийн төлөвлөгөө, нөлөөллийг бууруулах ажлуудад нэмэлт мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэхийг зорьсон байна. БОНБНУ-ий нэмэлт олон нийтийн хэлэлцүүлгийг 2020 онд зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Хэлэлцүүлэгт нийт 50 хүн оролцох бөгөөд баг, сум, аймгийн түвшний орон нутгийн захиргаанаас төлөөлөгчид оролцоно.

## 6.2 Оролцогч талуудын болон харилцаа холбооны менежментийн төлөвлөгөө

Оролцогч талуудын болон харилцаа холбооны менежментийн төлөвлөгөөг (ОТХХМТ) БОНБНУ-ийн ил тод байдлын хангах ажлын хүрээнд боловсруулсан бөгөөд тус төлөвлөгөөнд дараах зүйлсийг агуулна. Үүнд:

- Танилцуулга
- Төслийн тодорхойлолт
- Оролцогч талуудын хамтын ажиллагаа, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой эрх зүйн зохицуулалт
- Өмнөх оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагаанууд
- Оролцогч талуудын тодорхойлолт
- БОНБНУ-ий явцад хийгдсэн нэмэлт хамтарсан ажлууд
- Оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжих хөтөлбөр
- Санал гомдлын менежмент
- Хяналт шинжилгээ
- Сургалт
- Аудит ба тайлагнах
- Үүрэг хариуцлага

ОТХХМТ нь гол оролцогч талуудыг тодорхойлж, хариу арга хэмжээ болон санал гомдлыг хэрхэн шийдвэрлэх хэлэлцүүлгийн арга барилыг тодорхойлдог. Тус баримт бичиг нь оролцогч талуудыг тодорхойлох, хамтын ажиллагааны хэрэгцээ шаардлагууд өөрчлөгдөхөд тогтмол шинэчлэгдэх “амьд” баримт бичиг байна.

## 6.3 Санал гомдол шийдвэрлэх журам

ОТХХМТ-д тусгасан санал гомдлыг шийдвэрлэх механизмыг компанийн дотоод болон гадаад оролцогч талуудын санал гомдлыг шийдвэрлэх механизмд үндэслэн боловсруулсан байна. Үүнийг бүх оролцогч талуудад нээлттэй байлгах бөгөөд оролцогч талуудын төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлтэй холбоотой санал гомдлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд ашиглана. Энэ нь компанид оролцогч талуудын санал гомдлуудад тохирох хариу арга хэмжээг цаг тухайд авч хэрэгжүүлэх боломжийг олгоно.

Аливаа санал хүсэлтийг бичгээр захидал, цахим шуудан эсвэл Компанийн гомдлын маягтын дагуу ирүүлж болно (Хавсралт 1-ийг үзнэ үү).

- Анхаарах: Эрдэнэ Монгол ХХК-ын Олон нийттэй харилцах хэлтэс
- Шуудангийн хаяг: Монруд ХХК-ийн байр, 2 давхар, НҮБ-ын гудамж 6/6, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс



- Утас: +976 11 319758
- Факс: +976 11 315988
- И-мэйл хаяг: [info@erdene.com](mailto:info@erdene.com)
- Компанийн вэбсайт <https://www.erdene.com/en/contact/>

Түүнчлэн санал гомдлыг амаар мэдүүлж болох бөгөөд Олон нийттэй харилцах мэргэжилтнүүд тухайн санал гомдлыг (эсвэл компанийн бусад төлөөлөл бүхий ажилтнууд) баримтжуулж авна.